



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН
АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ҮР ӨГӨӨЖИЙГ ТООЦОХГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД: ГНАГ-2023/25-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор **Д.Энхболд**

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер **Б.Батчимэг**

Утас: 262451 Цахим хаяг: batchimegb@audit.gov.mn

Ахлах аудитор **Х.Энх-Амгалан**

Утас: 262451 Цахим хаяг: enkhmagalankh@audit.gov.mn

Аудитор **М.Доржмаа**

Ш.Наранбаатар

О.Дашхонгор

Х.Шинэбаяр

Н.Онон



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Г.Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.5, 21 дүгээр зүйлийн 21.3, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1."Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, төсөл хэрэгжүүлэгч нэгжид тус тус хүргүүлж, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор ирүүлж, биелэлтийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яам (Б.Жавхлан), Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам (Д.Болорчулуун)-д зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт даалгасугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.



Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2023\Tushaal\EA-б\А Тушаал\1004 GNAG-3.Docx

0001010890

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
ААН	Аж ахуйн нэгж
ҮАГ	Үндэсний аудитын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
БНБУ	Бүгд найрамдах Беларус улс
АХБ	Азийн хөгжлийн банк
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШУТТ	Шинжлэх ухаан, технологийн төсөл
ОХУ	Оросын холбооны улс
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖДҮЭ	Жижиг дунд үйлдвэрлэгч эмэгтэйчүүд
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ХААГ	Хөдөө аж ахуйн газар
ТУХ	Төслийн удирдах хороо
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Цахим системд бүртгэлгүй төслүүд	9
Хүснэгт 2	Төслийн зээлийн гэрээ хэлэлцээрийн мэдээлэл	10
Хүснэгт 3	Төслийн зээлийн гэрээний хугацаа	11
Хүснэгт 4	Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ	12
Хүснэгт 5	Төслийн зорилго	13
Хүснэгт 6	Санхүүжилт, ажлын гүйцэтгэл	13
Хүснэгт 7	Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт	14
Хүснэгт 8	“ХАА, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд олгосон тоног төхөөрөмж	16
Хүснэгт 9	Төслийн ерөнхий үзүүлэлт	17
Хүснэгт 10	Төслийн ерөнхий үзүүлэлт	18
Хүснэгт 11	Зээлийн батлан даалтын нөхцөлд оруулсан өөрчлөлт	21
Хүснэгт 12	Тоног төхөөрөмжийн нэр, үнийн нэгтгэсэн судалгаа	23
Хүснэгт 13	Төслийн бүрэлдэхүүний хуваарийн өөрчлөлт сая.ам доллар	25
Хүснэгт 14	Төслийн нэгжийн зарцуулалт задаргаа сая.төг	27
Хүснэгт 15	Нэг ба түүнээс дээш санхүүжилт авсан ААН /сая.төг/	28
Хүснэгт 16	ЖДҮ дамжуулан зээлийн мэдээлэл	30

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь их наяд.төг	6
Дүрслэл 2	ХАА-н салбарын зээл, тусламжийн ерөнхий мэдээлэл	7
Дүрслэл 3	ХАА-н тэргүүлэх чиглэлийн бодлого	8
Дүрслэл 4	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд	9
Дүрслэл 5	Төслийн салбараарх ангилал	15
Дүрслэл 6	Өвлийн хүлэмжийн суурь болон шилэн фасадын каркас угсарсан байдал	25
Дүрслэл 7	Төслийн бүтэц, бүрэлдэхүүн	26
Дүрслэл 8	Хөтөлбөрийн өнөөдрийг хүртэлх бүтцийн өөрчлөлт	27
Дүрслэл 9	Төслийн зарцуулалт задаргаа он, төрөл бүрээр сая.төг	29
Дүрслэл 10	Нийт санхүүжилтийн мэдээлэл	32
Дүрслэл 11	ХАА-н салбарын зээл, тусламжийн зарцуулалтын хувь хэмжээ	32
Дүрслэл 12	Өвлийн хүлэмжийн гадна, дотор талаас /Ерөө сум/	33
Дүрслэл 13	Зоорины гадна тал /Ерөө сум/	34
Дүрслэл 14	ХАА хөдөөгийн хөгжлийн төслийн хүрээнд төслийн хэрэгжүүлэх 4 багц ажлын задаргаа: Төслийн 1 болон 2 дугаар багцын хүрээнд хийсэн ажлууд	38
Дүрслэл 15	Төсөлд оролцогч ААН-ийн борлуулалт, экспортын өсөлт /сая.төг/	39

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, нэмэлт санхүүжилтийн мэдээлэл	42-43
Хавсралт 2	Трактор, техник, тоног төхөөрөмжийн үнэ, болон борлуулалтын мэдээ	44
Хавсралт 3	Түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан ХАА-н ААН-ийн жагсаалт сая.төг /2020-2023 он сая.төг/	45-46
Хавсралт 4	Түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан ААН экспортын мэдээ /2020-2023 сая.төг/	46-47



Үндэсний аудитын газрын
Гүйцэтгэл-Нийцлийн газар

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэл-Нийцлийн аудитын
газрын захирал, тэргүүлэх
Аудитор Д.Энхболд

Аудитын менежер
Б.Батчимэг

Ахлах аудитор
Х.Энх-Амгалан
Аудитор
М.Доржмаа
Ш.Наранбаатар
О.Дашхонгор
Х.Шинэбаяр
Н.Онон

Аудитын дүн, дүгнэлт,
зөвлөмжтэй холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж лавлах,
холбогдох саналаа өгөхийг хүсвэл
261456 дугаарын утас, 323266
дугаарын факсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын
www.audit.mn цахим хуудаснаас
үзнэ үү.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

2023 он

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ..... 7

БҮЛЭГ 1. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ ДУУССАН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ НЭГДСЭН ШАЛГУУР, АРГАЧЛАЛЫГ БАТАЛЖ МӨРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА 9

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн зорилго нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж, төрөөс баримтлах хөгжлийн бодлоготой нийцэж байна..... 9

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөлтийн шалгуурыг бүрэн хангахгүй байна 13

Зарим төсөл цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж удааширсан, санхүүжилтийг үр дүнгүй зарцуулсан, ажлын явц зогссон байна..... 14

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил-нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд арилжааны банкаар дамжуулан нийт 128.7 тэрбум төгрөгийн зээл олгожээ 15

Дамжуулан зээлийн гэрээ байгуулаагүй, шаардлага хангаагүй арилжааны банканд зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн байна.....16

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2 ААН төслийг бүрэн дуусгаагүй, зарим төслийн хэрэгжилтийн талаар тайлагнаагүй байна17

Төслийн санхүүжилтээр бий болсон өмч хөрөнгө ашиглалтгүй, бүртгэлгүй байна..... 19

Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуйн төслийн хүрээнд зарим байршилд ажил зогссон, хэрэгжилтийн хувь өмнөх оны үзүүлэлтээс буурсан ч шинэ байршилд арга хэмжээ төлөвлөж байна20

Зээлийн хөрөнгөөр гаргаж буй батлан даалтын чанарыг сайжруулах, төслийн шаардлага, шалгуурыг хангаж ажиллах шаардлагатай байна.....21

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр төслийн зааварт өөрчлөлт оруулснаар батлан даалтын хэмжээ нэмэгджээ 22

Төслийн удирдах хороо байгуулаагүй, зээлийн батлан даалтын сангийн дүрмээр төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна 23

Зээлийн хөрөнгийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон нь эргэн төлөлт хийгдэхгүйд хүргэжээ 24

Барилга угсралтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 25

Зээлийн хөрөнгийг тусламж хэлбэрээр тооцоо судалгаагүй, үр дүн нь тодорхой бус арга хэмжээнд зарцуулсан байна 26

Экспортыг дэмжих төслийн гадаад болон дотоод зөвлөхийн зардал нь нийт зардлын 44.2 хувийг эзэлж байна 27

ААН нь зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж, зээлийн эргэн төлөлтөөр төслийг дахин санхүүжүүлж байна 31

БҮЛЭГ 2. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУР ХАНГААГҮЙ, ЗУРАГ ТӨСӨВ, ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ТООЦОО СУДАЛГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.....32

Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний ашиглалт хангалтгүйгээс үр өгөөж тооцох боломжгүй.. 32

Тусламжаар бий болгосон хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна .. 33

Зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн ил тод байдал хангаагдахгүй байна..... 34

Зарим төслийн үр дүнг тооцоогүй ч тухайн төсөлд нэмэлт санхүүжилт авч үргэлжлүүлж байна..... 37

Дүгнэлт 40

Зөвлөмж..... 41

Хавсралт..... 42

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх.

Аудитад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд болон төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч нэгж, холбогдох байгууллагын үйл ажиллагаа, 2016-2022 онд хэрэгжүүлсэн болон хэрэгжиж байгаа нийт 9 төслийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамрууллаа.

Аудитыг Засгийн газрын шугамаар болон хандивлагч орон, олон улсын байгууллагаас Хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаад зээл, тусламжийн мэдээ, төслийн нэгжийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангууд, дамжуулан зээлд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын зээлтэй холбогдох үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, бусад нотлох баримт материалд үндэслэн хийв.

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000, “Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817:2020”, АДБОУС 5400-5499 Улсын өрийн аудитын удирдамж, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан шалгагдагч байгууллагын ажил хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асууж тодруулах болон судалгаа авах, тулган баталгаажуулах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан төлөвлөсөн арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлтэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг аудитад шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”;

- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж;
- Санхүүжүүлэгчтэй байгуулсан зээлийн гэрээ;

Аудитын баг, бүрэлдэхүүн

Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Батчимэг хэрэгжүүлж, Ахлах аудитор Х.Энх-Амгалан, аудитор Ш.Наранбаатар, М.Доржмаа, Х.Шинэбаяр, О.Дашхонгор, Н.Онон болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын материаллаг илрүүлэлт

Аудитаар нийт 56.8 тэрбум төгрөгийн 58 зөрчил илрүүлж, 52.5 тэрбум төгрөгийн зөрчил арилгуулах 41 албан шаардлага, 4.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 17 зөвлөмж өглөө.


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹ дэх хэсэгт 7 төрлийн зориулалтаар өр үүсгэж болно гэж заасан, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т “Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх”, 12.1.5-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх” заалтуудыг тус тус үндэслэн ХАА-н салбарт хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

Монгол Улсын хөдөө, аж ахуйн салбар нь мал аж ахуй, газар тариалан гэсэн 2 дэд салбараас бүрддэг ба үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэгцээг хангахад зориулагдаж байна.

Монгол Улсын ХАА-н салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2015 онд ДНБ-ий 14.9 хувийг эзэлж байсан бол 2021 онд 14.0 хувь, 2022 онд 14.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 1. ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь их наяд.төг



Эх сурвалж: ҮСХ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, үйлдвэрлэлийн аргаар

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2015 онтой харьцуулахад биет хэмжээгээрээ 1.1 их наяд төгрөг буюу 34.3 хувийн өсөлтийг үзүүлжээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд хөдөө, аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтыг үзэхээр төлөвлөсөн бол аудитын гүйцэтгэлийн явцад санхүүжүүлэгч байгууллагын дэргэд хэрэгжсэн 12 төслийн мэдээлэл “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан” цахим систем (www.odamis.mof.gov.mn) - д бүртгэлгүйгээс аудитын хамрах хүрээг хэрэгжиж байгаа төслийн хүрээнд үзсэн болно.

Дээрх шалтгаантай холбоотой аудитын дэд зорилтын 2 дахь хэсэг буюу хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх асуудлыг бусад дэд сэдвийн хүрээнд дүгнэн ажиллалаа.

Хөдөө, аж ахуйн чиглэлээр Дэлхийн банкны 2, Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн 3, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 1, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын санхүүжилтээр нийт 213.7 сая ам.доллар, 3.8 сая евро, 5.0 тэрбум иений хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжаар

¹ 12.1. Засгийн газар дараах зориулалтаар өр үүсгэж болно:

12.1.1. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх.

12.1.2. төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх.

12.1.3. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих.

12.1.4. Өрийг дахин санхүүжүүлэх.


12.1.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх.

12.1.6. Улсын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монгол банкны гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

12.1.7. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх

нийт 9 төслийг төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэх нэгжүүд хариуцан хэрэгжүүлж байна.

Дүрслэл 2. ХАА-ын салбарын зээл, тусламжийн ерөнхий мэдээлэл



Эх сурвалж: Сангийн яамны гадаад зээл, тусламжийн судалгаа

Үүнээс АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт", "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл"-үүд хэрэгжиж дууссан бөгөөд нэмэлт санхүүжилт болон зээлийн эргэн төлөлтөөр төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ 1 ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ ДУУССАН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ НЭГДСЭН ШАЛГУУР, АРГАЧЛАЛЫГ БАТАЛЖ МӨРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА


Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн зорилго нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж, төрөөс баримтлах хөгжлийн бодлоготой нийцэж байна

1.1 Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамдын эрхлэх асуудлын хүрээг тогтоосон бөгөөд 2000 оноос хойш ХХААХҮ-ын салбарын эрхлэх асуудлын хүрээнд дараах 14 асуудал хамаарч байна. Үүнд:

- Хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- Хүнсний аюулгүй байдлын асуудал;
- Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- Газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- Мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- Мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;
- Бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
- Мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- Малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;
- Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал;
- Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;
- Дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;
- Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

1.2 Мөн Улсын Их Хурал, Засгийн газраас ХАА-н салбарын урт, дунд хугацааны тэргүүлэх чиглэл, бодлогын зорилтуудыг агуулсан дараах баримт бичгүүдийг баталжээ.

Дүрслэл 3. ХАА-ын тэргүүлэх чиглэлийн бодлого



Эх сурвалж: ХАА-н салбарын бодлогын баримт бичгүүд

1.3 Дээрх бодлогын баримт бичгүүд болон ХАА-н салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үндсэн зорилт нь байгальд ээлтэй, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилготой байна.

1.4 Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Дүрслэл 4. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд

<p>Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тээжлэл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бусчилсан байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлож, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно.</p>
<ul style="list-style-type: none"> Газар тариалан, хөдөө аж ахуйн төв Дархан, Сэлэнгэ бүс нутагт агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, “Монгол мал-1” арга хэмжээг хэрэгжүүлнэ. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна. 	<ul style="list-style-type: none"> Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Эх сурвалж: Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

1.5 Дээрх зорилт арга хэмжээг дунд хугацаанд бүрэн хэрэгжүүлснээр төрөөс ХАА-н салбарт баримталж буй бодлогын хүрээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэж, дотоодоос хүнсний хэрэгцээ хангагдах, экспорт дэмжигдэхээр байна.

1.6 Мал аж ахуй, газар тариалан, жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг бий болгох, хөгжүүлэхэд шаардлагатай зарим төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа нь Засгийн газрын урт болон дунд хугацааны бодлогын зорилтыг хангахад дэмжлэг болжээ.

1.7 Монгол Улсад зээл, тусламжийн харилцааг 2003 оны Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн бөгөөд Өрийн удирдлагын тухай хууль 2015 онд батлагдсанаар зөвхөн зээлийн харилцааг хуулийн хүрээнд хамруулжээ.

1.8 Харин Монгол Улсад олон улсын байгууллага, хандивлагч орноос өгсөн тусламжийг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-аар зохицуулж байна.

1.9 Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан мэдээллийн www.odamis.mof.gov.mn цахим системд хөдөө, аж ахуйн салбарын 15 төсөл бүртгэлтэй байгаагаас 4 төсөл хэлэлцээрийн шатанд, 2 төсөл хэрэгжиж дууссан бол хэрэгжиж байгаа 9 төслийн ашиглалтыг аудитад хамруулав.

1.10 Харин олон улсын байгууллага, хандивлагч орны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа дараах 12 төслийн мэдээлэл “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан” цахим систем (www.odamis.mof.gov.mn)-д бүртгэлгүй байна.

Хүснэгт 1. (www.odamis.mof.gov.mn) цахим системд бүртгэлгүй төслүүд

№	ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭР	ТАЙЛБАР
1	Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл	Швейцарийн хөгжлийн агентлаг санхүүжилтээр донор байгууллагын дэргэд хэрэгжсэн.
2	Үхрийн сүрьеэ, Адууны ям өвчний хяналт /Япон болон Монгол улсын хамтарсан ШУТТөсөл (SATREPS project)/	МЭХ-нд хэрэгжиж байгаа
3	ЖАЙКА, Төрийн болон хувийн хэвшлийн малын эмч нарын практик ур чадварыг бэхжүүлэх төсөл	Донор байгууллагын дэргэд хэрэгжиж байгаа
4	ТТ 9887 МОН – Тэжээлийн Тогтвортой Менежмент /техник туслалцаа/	

5	ХАА нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл ТА-8960:МОН /техник туслалцаа/	АХБ-ны санхүүжилтээр “Монконсалт” ХХК хэрэгжүүлж байна
6	Тогтвортой Хөдөө аж ахуй төсөл /буцалтгүй тусламж/	ХБНГУ-ын санхүүжилтээр донор байгууллагын дэргэд хэрэгждэг
7	Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөөний төсөл /техник туслалцаа/	Жайка санхүүжилтээр донор байгууллагын дэргэд хэрэгждэг
8	Хоршоодод суурилсан хөдөө аж ахуйн түүхий эдийн тогтвортой хангамжийн төсөл /техник, туслалцаа/	АХБ-ны дэргэд хэрэгждэг
9	Монгол малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийн 2 дугаар үе шат/буцалтгүй тусламж/	ОХУ-ны ЗГ-ын санхүүжилтээр хэрэгждэг
10	Монгол ногоо-2 хөтөлбөр 1 дүгээр шат /буцалтгүй тусламж/	ШХА-ын санхүүжилтээр донор байгууллагын дэргэд хэрэгжсэн.
11	Монгол ногоо-2 хөтөлбөр 2 дугаар шат /буцалтгүй тусламж/	
12	/Ковид 19-ийн Хямралын Үе дэх Монгол Улсын Хүнсний Аюулгүй Байдлын Эрсдэлийн Удирдлага ТТ 6584 МОН	АХБ-ны санхүүжилтээр “Монконсалт” ХХК хэрэгжүүлж байна

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны албан бичиг

1.11 Дээрх төсөл хөтөлбөр нь цахим систем (www.odamis.mof.gov.mn)-д бүртгэлгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4²-д заасан төсвийн бүрэлдэхүүн хэсэгт багтаагүйгээс төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчим алдагдсан байна.

1.12 Мөн зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь Өрийн удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг, 6 дугаар зүйлийн 6.6.1³, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын /цаашид СС-ын 2021 оны журам гэх/ 7.3⁴-д заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

1.13 Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүртгэх чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд энэхүү чиг үүргийн хүрээнд холбогдох этгээдээс шаардлагатай баримт, мэдээллийг гаргуулах эрхтэй”- гэж заасан ч хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

1.14 Иймд дээрх төслүүдийн санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч, хөрөнгө санхүүжилтийн дүн, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөл, буцалтгүй тусламжийн талаарх мэдээллийг Өрийн удирдлагын тухай хуулийн 39.2.1⁵-д заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан” цахим системд бүртгэх шаардлагатай байна.

1.15 ХХААХҮЯ-ны захиалгаар хэрэгжүүлж байгаа төслийн хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг УИХ-аар дараах байдлаар баталсан байна. Үүнд:

Хүснэгт 2. Төслийн зээлийн гэрээ хэлэлцээрийн мэдээлэл

№	Төслүүдийн нэр	Зээлийн хэлэлцээр		Зээлийн дүн	
		Баталсан огноо	Гэрээний дугаар		
1	“Трактор, ХАА- н техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” /зээл/	2021.08.31	112/00236091/210034-1	3.8	сая евро
2	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох	2016.02.19	МОН-3338	60.0	сая.ам доллар
3	“ХАА, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төсөл /зээл/	2015.11.10	3287-MON 3288-MON SF	49.2	сая.ам доллар
4			3895-MON(COL)	40.0	сая.ам доллар

² 6.3.4-д “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”

³ 6.6.1. өрийн удирдлагын талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх, хуулийн шаардлага, хэм хэмжээг зөрчихгүй байх, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх;

⁴ 7.3.Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

⁵ улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдэл;

	“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” /зээл, буцалтгүй тусламж/	2020.03.20	3896-MON(OCR) 9205-MON	2.0	сая.ам доллар
5	ЖДҮ-г дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	2011.01.27	МОН-П9 МОН-П7	5.0	тэрбум иен
6	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /буц.тусламж/		МОН-9192, МОН-0684/	3.5	сая.ам доллар
7	Экспортыг дэмжих төсөл /зээл/	2016.11.04	5879-MN	20.0	сая.ам доллар
8	МАН-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл / зээл/	2020.02.07	6508-MN	30.0	сая.ам доллар
9	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /зээл/-1, Нэмэлт санхүүжилт-2, Буцалтгүй тусламж-3	2017.06.09	I-836-MN 200001604 FSS-1MN	9.0	сая.ам доллар

Эх сурвалж: УИХ-ын тогтоол, төслүүдийн зээлийн гэрээ хэлэлцээр

1.16 Төслүүдийг АХБ, Дэлхийн банк, ХАА-г хөгжүүлэх сан, ЖАЙКА зэрэг олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа бол хэрэгжих хугацааны хувьд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Төслийн зээлийн гэрээний хугацаа

№	Төслүүдийн нэр	Төслийн хугацаа		Хэрэгжилтийн төлөв	
		эхлэх	дуусах	дууссан	хэрэгжиж байгаа
1	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/	2018.05.10	2023.09.30		1
2	“Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” /зээл/	2021.05.13	2027.10.15		1
3	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох /зээл/	2016.04.14	2023.12.31		1
4	“ХАА, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл	2016.03.01	2021.06.30	1	
5	“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” /зээл, буцалтгүй тусламж/	2020.05.06	2026.9.30		1
6	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	2011	2018	1	
7	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /буц. тусламж/	2018.03.26	2023.12.31		1
8	Экспортыг дэмжих төсөл /зээл/	2020.01.01	2023.12.31		1
9	МАН-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл / зээл/	2020.02.06	2025.06.30		1
НИЙТ				2	7

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны төслийн мэдээлэл

1.17 Хүснэгтээс үзэхэд “ЖДҮ-г дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл 2018 онд бүрэн хэрэгжиж дууссан, “ХАА, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл 2021 оны 6 сард дууссан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан журмын 10.10⁶-д заасны дагуу үр нөлөөний тайланг холбогдох төслийн нэгж хийгээгүй байна.

1.18 Дээрх “ХАА, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хэрэгжиж дууссан ч зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээр тус төслийг үргэлжлүүлэхээр шийдвэрлэжээ.

1.19 Тухайн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссанаас хойш тодорхой хугацааны дараа үр нөлөөний үнэлгээг хийх тухай журмаар зохицуулсан хэдий ч ямар шалгуур, аргачлалаар үнэлж дүгнэх нь тодорхойгүй, баримт бичгийг батлаагүй байна.

1.20 Иймд Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төслийн үр нөлөөг үнэлэх нэгдсэн шалгуур, аргачлалыг баталж мөрдүүлэх шаардлагатай байна.

⁶ 10.10. Төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусах шатанд төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төсөл, арга хэмжээний үр дүнгийн үнэлгээ хийж, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжиж дууссанаас хойш 1 (нэг) жилийн дараа үр нөлөөний үнэлгээг хийж тайланг цахим системээр тайлагнана.

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөлтийн шалгуурыг бүрэн хангахгүй байна

1.21 ХАА-н салбарт гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг салбарын бодлого зорилттой уялдуулан эх үүсвэрийг шийдвэрлэж байгаа ч төлөвлөлтийн шаардлагыг хангаагүйгээс зарим төслийн хэрэгжилт зорилтот түвшинд хүрээгүй байна.

1.22 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16⁷, 4.1.17⁸-т тодорхойлсон шалгуур хангасан арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг тайлагнах, Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21⁹-т заасны дагуу хэрэгжүүлэхэд тоо хэмжээ, цаг хугацааны болон чанарын шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай байна.

1.23 Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээний арга хэмжээний биелэлт тухайн жилийнхээ зорилтот түвшин хангаагүй гэж дүгнэсэн.

Хүснэгт 4. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ/ 2022 он/

	Төсөл, арга хэмжээний нэр	Зорилтот түвшин болон үнэлгээ	%
1	Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Төвийн бүсийн үхэр сүргийн 6.6 сая толгой /20.5 хувь/ малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.	30
2	Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулах	Хөнгөн үйлдвэрийн салбарын 4 лаборатори, төвүүдийн тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна.	50
3	Цахим ХАА, ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг байгуулж, ХАА-н биржийн шинэчлэлийг хийж, хоршооны бүтцэд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох загвар хоршоод байгуулах	Загвар 10 хоршоотой болсон байна.	30
4	ЖДҮ-г дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх	Шинээр нэмж 2000 ажлын байр бий болсон байна	53
5	ЖДҮ-ийн бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх. ЖДҮЭ-дийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулах, томруулах бодлогыг боловсронгуй болгох	Орон нутгийн нэгдсэн бүтцийг бий болгоно.	50
6	Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	90.0 мянган тн мах экспортолсон байна	30
7	Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна	30
8	“Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	“Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	30
9	Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх	Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр шинээр бий болгоно.	50
10	Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэхэд мах, сүүний цэвэр үүлдрийн өсвөр үхрийг өсгөн үржүүлэх, худалдан авч иргэн, аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлээр олгох. Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих. Малын тэжээл тариалагч иргэн, ААН-г дэмжиж, хөнгөлөлт үзүүлэх	Махны цэвэр үүлдрийн үхрийн тоог 1000 толгойгоор, сүүний цэвэр үүлдрийн үхрийн тоог 1000 толгойгоор тус тус нэмэгдүүлнэ. Тэжээлийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ	30
11	Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох	Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох	50

7 "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ;

8 4.1.17. "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээ;

9 "төсөл, арга хэмжээ" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.17-д заасныг.

4.1.17. "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээ;

4.1.21. "төсөл хэрэгжүүлэгч" гэж гадаад зээллэгийн хөрөнгөөр санхүүжих төслийн хэрэгжилтийг харцуцах чиг үүрэг бүхий олон улсын гэрээ, төслийн баримт бичиг, гэрээнд оролцогч талуудын хооронд байгуулсан бусад тохиролцлын баримт бичигт заасан эрх бүхий байгууллагыг;

12	Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулах	70.0 мянган га талбайд тослог ургамал тариалахаас төрийн дэмжлэгээр 230 тн тослог ургамлын үр импортоор нийлүүлж, 38.0 мянган га талбайд тариалах боломжийг бүрдүүлнэ. Нийт 56.0 мянган тн ургац хураан авна. Үйлдвэрийн хэрэгцээний 62 хувийг дотоодын ургацаас хангасан байна	65 .0
----	--	---	----------

Эх сурвалж: Аудитын тайлангаас

1.24 Зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 30-65 хувьтай байгаа нь төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн шалгуур бүрэн хангагдаагүйгээс ажлын явц гүйцэтгэл зорилтот түвшинд хүрэхгүй байх шалтгаан болж байна гэжээ.

1.25 ХАА-ын салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн хувьд ч төлөвлөлттэй холбоотой алдаа зөрчлүүд давтагдаж байгаа нь төслийн явцыг удаашруулах, үр дүнгүй болгох суурь шалтгаан болж төслийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймгийн Халиун сумын Ёлтон, Жаргалан сумын Цахир,
- Завхан аймгийн Тэлмэн сумын Хүрэн тал, Улиастай сумын Ногоон хашаа,
- Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Алтай сумын Боомын ам,
- Төв аймгийн Батсүмбэр сумын Сөгнөгөр,
- Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Улаан дэл зэрэг байршлуудад төлөвлөсөн услалтын системийг шинэчлэн сайжруулах барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг батлагдсан ажлын даалгаваргүйгээр боловсруулж батлуулсан. Байгаль орчны үнэлгээ болон зургийн даалгаврууд ерөнхийдөө нэг ижил байдлаар хийгдсэн гэсэн мэргэжлийн экспертийн дүгнэлт гарсан,
- Эдгээр төслүүдийн зураг төсөл алдаа ихтэй, дутуу төлөвлөлттэй, тооцоо судалгаагүйгээр хийгдэж магадлалын дүгнэлтээр батлагдсан,
- Зарим төслийн зураг төсөлд услалтын системийн цахилгааны эх үүсвэрийг тооцоолоогүй орхигдуулсан,
- Төслийн талбайг дайрч байгаа цахилгаан дамжуулах агаарын шугам, мод тариалсан талбай, бусад жижиг барилга байгууламжийг нүүлгэн шилжүүлэх, чөлөөлөх ажлын зураг төсөл, төсөв зардал зэргийг тооцоолоогүй орхигдуулсан зэрэг зөрчлүүд байна.

1.26 Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8¹⁰-д, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан журмын 6.2¹¹-дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

Зарим төсөл цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж удааширсан, санхүүжилтийг үр дүнгүй зарцуулсан, ажлын явц зогссон байна

1.27 Хөдөө аж ахуйн чиглэлээр 21 аймаг, сумдад хэрэгжиж буй төслүүд дараах зорилгын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

Хүснэгт 5. Төслийн зорилго

	Төслийн нэр	Төслийн зорилго
1	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ зээл	“Монгол мал”, “Хоршооны хөгжил” үндэсний хөтөлбөрүүдтэй нийцүүлэн төсөл хэрэгжиж буй аймгуудын малчин өрхүүд, аймаг, сумдын иргэдийн амьжиргааг дээшлүүлж ядуурлыг бууруулах
2	“Трактор, ХАА-н техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” /зээл/	Хөдөө аж ахуйн салбарт гадаадын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр газар тариалан болон аж ахуй эрхлэгчдийг техник% тоног төхөөрөмжөөр хангах, улмаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд
3	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох	Төслийн зорилго ЖДҮЭ санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой үйл ажиллагааг сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлэн өсөлтийг дэмжих, ажлын байр бий болгох

¹⁰ 11.1.8.зээл, тусламжийн санхүүжилт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх, үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх

¹¹ Журмын 6.2. Харьгалах төрийн захиргааны төв байгууллага нь хууль болон энэ журамд заасан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг салбарын хөгжлийн бодлого, зорилт, тэргүүлэх чиглэл, өмнө хэрэгжсэн төслүүдтэй уялдуулах, давхардуулахгүй байх, салбарын болон салбар хоорондын зохицуулалтыг хангах үүргийн дагуу хянан, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн, ерөнхий танилцуулгын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4	"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт" төсөл /зээл/	Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн ААН-дэд хөрөнгө оруулах замаар ХАА, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байр бий болгох, МУ-ын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах
5	"Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" /зээл, буцалтгүй тусламж/	Усалтын системүүдийг шинээр барих, сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, борлуулалт, агуулахын дэмжлэг үзүүлэх замаар хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэн ногоочид, тариаланчдын чадавх, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах
6	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	Ядуурлыг бууруулж, тогтвортой хөгжлийг дэмжих, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлж хувийн хэвшлийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, Төсөлд оролцогч банкууд болон ЖДҮ бизнес эрхлэгчдийг чадавхжуулах
7	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /буц. тусламж/	Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариалагч иргэн, хоршоог дэмжиж хүнсний ногооны үйлдвэрлэлийн ажлыг механикжуулах, механикжсан зорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилготой
8	Экспортыг дэмжих төсөл /зээл/	Уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх.
9	МАН-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл /зээл/	Мал сүргийн эрүүл мэнд, ашиг шим, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшигийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны төслийн мэдээлэл

1.28 Эдгээр төсөл, арга хэмжээний санхүүжилт болон ажлын гүйцэтгэл 2023 оны 8 дугаар сарын байдлаар нийт 213.7 сая ам.доллар, 3.8 сая евро, 5.0 тэрбум иен буюу 781.1 тэрбум төгрөгийн зээл, тусламжаас 560.7 тэрбум төгрөгийг ашиглажээ.

Хүснэгт 6. Санхүүжилт, ажлын гүйцэтгэл

/сая.төгрөг/

№	Төслийн нэр	Зээлийн дүн	Зээлийн ашиглалт	Үлдэгдэл
1	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл	208,353.0	171,439.8	36,913.2
2	Трактор, ХАА-н техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл /зээл/	15,214.5	14,072.3	1,142.2
3	Экспортыг дэмжих төсөл	66,161.1	35,103.8	31,057.3
4	Мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	100,861.0	69,366.8	31,494.2
5	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн нэмэлт санхүүжилт	29,980.7	29,689.6	291.1
6	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	10,417.7	9,017.5	1,400.2
	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл нэмэлт санхүүжилт	1,736.3	1,475.3	261.0
7	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил 2 төсөл	127,837.1	127,837.1	-
8	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл (COL болон OCR) -I	87,855.5	27,515.2	60,340.3
	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл-II	6,945.1	347.3	6,597.8
	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл (COL болон OCR) 3896	51,046.5	206.0	50,840.5
9	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	74,700.0	74,700.0	-
	Нийт	781,108.5	560,770.7	220,337.8

Эх сурвалж: Сангийн яам

Аудитын хүрээнд төсөл тус бүрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил-нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд арилжааны банкаар дамжуулан нийт 128.7 тэрбум төгрөгийн зээл олгожээ

1.29 “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил-нэмэлт санхүүжилт” төслийн зорилго нь Монголын ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг илүү шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн ба дараах 4 үр дүнг зорилт болгон дэвшүүлсэн. Үүнд:

Үр дүн 1: Нэмүү өртгийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Үр дүн 2: Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэх.


Үр дүн 3: Аж ахуйн нэгжийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамж сайжруулах.

Үр дүн 4: Монголын бүтээгдэхүүний брэндийн хөгжүүлэлт.

1.30 Төслийн хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 50 ААН-д нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зорилгоор 128,776.2 сая төгрөгийн санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгохоор шийдвэрлэсэн байна. (дэлгэрэнгүйг хавсралт-с харна уу)

1.31 Төслийн үндсэн зорилго нь агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар ХАА, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулахад чиглэсэн байна. Дэд төслүүдийг салбараар авч үзвэл:

Дүрслэл 5. Төслийн салбарын ангилал



Эх үүсвэр: ТХН

1.32 Төсөлд оролцогч ААН-ийн материал болон арилжааны банкны зээлийн хороогоор батлан ирүүлсэн саналыг ТХН дахин бизнесийн болон санхүүгийн, байгаль орчин, нийгэм, жөндөрийн гэсэн 4 төрлийн үнэлгээ хийж, 1.0 сая ам.доллараас дээш хэмжээтэй зээлийг АХБ-ны зөвшөөрөлтэйгөөр ТУХ-оор баталдаг байна.

1.33 Төслийн хүрээнд нийт 45 дэд төслийг АХБ-ны хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр 2015 онд MON-3287 дугаартай зээл, тусгай сангаас санхүүжих MON-3288 дугаартай зээлээс санхүүжиж нийт 106,757.0 сая төгрөгийн дамжуулан олгох зээлийн гэрээ байгуулсан байна.

1.34 Дээрх үндсэн гэрээний хэрэгжилт 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон ба дамжуулан зээлийн эргэн төлөлтөөр санхүүжих нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээлийн хүрээнд 2021-2022 байдлаар нийт 5 ААН-д 22,019.2 сая төгрөгийн дамжуулан зээлийн гэрээг ТУХ-ны хурлаар хэлэлцүүлж баталсан байна.

1.35 “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Сангийн яам, ХХААХҮЯ-ны хооронд 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр дамжуулан зээлдүүлэх №200515/01/161/56 дугаартай гэрээ байгуулан нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээлийг үргэлжлүүлэхээр болсон байна.

Дамжуулан зээлийн гэрээ байгуулаагүй, шаардлага хангаагүй арилжааны банканд зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн байна

1.36 Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 20.3¹²-т

¹² ТХН нь төслийн данс нээх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлэх ба Сангийн яамны зүгээс данс нээх хүсэлтийг ажлын 3 (гурав) хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

зааснаар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь төслийн тусгай болон дэд дансыг арилжааны банк, Монгол банк, Төрийн санд нээж, хааж болно гэж заажээ.

1.37 Сангийн яам төслийн хүрээнд арилжааны 6 банкттай /Хаан, Хас, Голомт, Худалдаа хөгжлийн, Үндэсний хөрөнгө оруулалтын, Улаанбаатар/ дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулсан боловч зээлийн эргэн төлөлтийг Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банканд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн нь Дамжуулан зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.3¹³-т заасныг зөрчсөн байна.

1.38 Үндэсний хөрөнгө оруулалтын банканд зээлийн төлөлт, хүүгийн орлого, харилцах дансны орлогоор 3,132.8 сая төгрөг, Чингис хаан банканд зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, харилцах дансны орлогоор 6,878.6 сая төгрөг нийт 10,011.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг 2016-2020 онд байршуулж мөнгөн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

1.39 Түүнчлэн Чингис хаан банк нь Монгол банкны “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан шалгуурыг хангаагүй байсан бөгөөд 6,794.9 сая төгрөг нь 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Иргэний хэргийн 181/ШШ2022/02734 дугаар шүүхийн шийдвэрээр 6,088.1 сая төгрөг болж өөрчлөгдөн ч шүүхийн шийдвэр хэрэгжээгүй байна.

1.40 Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1¹⁴-д заасны дагуу Сангийн яам дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, уг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

1.41 Дээрх авлагатай холбогдуулан ҮАГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд зөрчил арилгах зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй, шүүхийн шатанд хянан хэлэлцэгдэж байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2 ААН төслийг бүрэн дуусгаагүй, зарим төслийн хэрэгжилтийн талаар тайлагнаагүй байна

1.42 Төслийн 1-р багц нэмүү өртгийн сүлжээг дэмжих төслийн хүрээнд дамжуулан зээл авсан 2 ААН дараах шалтгааны улмаас төслийг бүрэн дуусгаж чадаагүй бөгөөд зээлийн төлбөрийг зээлдүүлэгчид төлж барагдуулсан байна. Үүнд:

- **Төв аймаг:** Их Аураг Орд ХХК нь зөгийн аж ахуйн төсөлд олгохоор дэмжигдсэн 380.00 сая төгрөгийн зээлийг 2018 онд авахаар гэрээ байгуулан 200.0 сая төгрөгийг олгож, үлдсэн 180.0 сая төгрөгийг компанийн борлуулалтын орлогоос шалтгаалан эрсдэлтэй гэж үзэн олгоогүй;
- Санхүүжилтийн үлдэгдэл бүрэн олгогдоогүй гэх шалтгаанаар төслийн зээлийг 2019 оны 9 дүгээр сард 181.0 сая төгрөг, 2020 оны 5 дугаар сард 199.0 сая төгрөгийг Их Аураг Орд ХХК буцаан төлж барагдуулжээ. Энэ нь зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүсгээгүй боловч бусад ААН-ийн боломжийг хязгаарласан, төслийн зорилгыг алдагдуулсан,
- **Орхон аймаг:** Жүр үр ХХК нь 2019 оны 11 дүгээр сард 1,600.0 сая төгрөгийн зээлийг сүүний үйлдвэр Эрдэнэт хотод байгуулахаар төлөвлөсөн ч төсөл коронавирус /ковид-19/ цар тахлын улмаас хэрэгжүүлээгүй, улмаар төслийг бүхэлд нь зогсоосон,
- Орхон аймагт төслийн хэрэгжилтийн талаарх анхан шатны баримт материалын бүрдэл хангалтгүй, барилгын ажил эхлээгүй, хэрэгжилт байхгүй тул зээлийн үлдэгдэл төлбөр 1,333.3 сая төгрөгийг 2023 оны 07 дугаар сард зээл олгосон банканд төлүүлж барагдуулсан байна.

1.43 Энэ нь зээлийн эргэн төлөлтөд эрсдэл учраагүй боловч Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан журмын 7.3¹⁵-т заасан төслийн үр дүн гараагүй байна.

¹³ 3.3. Сангийн яам нь Дэд зээлдэгчид дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг гагцхүү Дэд зээлдэгчээс тухай бүр гаргуулж авах эрхтэй.

¹⁴ 31.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, уг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

¹⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.44 АХБ-ны MON-3288(SF) зээлийн гэрээгээр төслийн хүрээний Үр дүн 2, 3, 4-ын техник туслалцаа хэрэгжиж байгаа ба зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт

Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт			
№	Үзүүлэлт	Хуваарилсан хөрөнгийн хэмжээ (Зээлжих тусгай эрх)	
		Ангилал (SDR)	мянган USD
1	Ажил	168.0	222.6
2	Тоног төхөөрөмж, материал	1,812.0	2,400.4
3	Зөвлөх үйлчилгээ	602.0	797.5
4	Нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалт	5,931.0	7,857.1
5	Сургалт	766.0	1,014.8
6	Маркетинг, брэнд хөгжүүлэлт	359.0	475.6
7	Төслийн удирдлага	549.0	727.3
8	Хүүгийн төлбөр	532.0	704.8
	Нийт	10,719.0	14,200.0

Эх сурвалж: Төсөл хэрэгжүүлэх нэгж

1.45 Уг зээлийн санхүүжилтээс 16 аймаг, нийслэлд 10,263.4 сая төгрөгийг төслийн хүрээнд зарцуулснаас 6,362.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үр дүн 2, 3-ын хүрээнд дараах аж ахуй нэгжид эргэн төлөх нөхцөлгүйгээр олгож, 3,900.8 төгрөгийг чадамжийг сайжруулах сургалт судалгаанд зарцуулсан байна.

Хүснэгт 8. “ХАА, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд олгосон тоног төхөөрөмж

№	Худалдан авах ажиллагааны нэр	Хамрагдагч ААН	Дүн /сая.төгрөг/
1	Өндөр ашиг шимт малын хүйс жолоодсон болон гүн хөлдөөсөн үр нийлүүлэх	Малын удмын сангийн үндэсний төв	620.2
2	Ноос, ноолууран ширхэгтийн шинжилгээний төхөөрөмж	ШУТИС, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн	508.2
3	Даавууны эрүүл ахуйн үзүүлэлт тодорхойлох тоног төхөөрөмж	ШУТИС, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн	85.0
4	Зөгийн бүтээгдэхүүнийг баталгаажуулах лабораторид тоног төхөөрөмж	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	103.9
5	Уурагт тэжээл үйлдвэрлэх төхөөрөмж (хөлдөөх, хатаах)	ХААИС, Мал аж ахуй биотехнологийн сургууль	70.1
6	Уурагт тэжээл үйлдвэрлэх төхөөрөмж (давхар ус нэрэгч)	Мал эмнэлгийн хүрээлэн, Хачиг шавж эгэл биетэн судлалын лаборатори	41.4
7	Оёмол бүтээгдэхүүний кластерын үйлдвэрлэлийн “Үйлдвэрлэл-сургалтын загвар төв”-ийн тоног төхөөрөмж	ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хувцас судлалын үндэсний төв	168.1
8	Нүүрс хүчлийн хийгээр хандлах аргаар чацарганын үрийн тос боловсруулах тоног төхөөрөмжийн иж бүрдэл	ШУТИС-ийн Техник технологийн судалгааны төв	945.3
9	Чацарганын талбайн шавьж баригч наалтын цех	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	107.8
10	Арьс ширний лабораторийн тоног төхөөрөмж	ШУТИС, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн	90.0
11	Лабораторийн агааржуулалтын төхөөрөмж/ кондиционер	ШУТИС, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн	121.4
12	Зөгийн бүтээгдэхүүнийг баталгаажуулах лабораторид урвалж авах	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	22.6
13	Сүүний чиглэлийн иж бүрдэл	Аж ахуй эрхлэгч, Хоршоо	416.9
14	Бэлчээрт инженерийн хийцтэй худаг	Ховд, Завхан, Хэнтий, Булган, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дундговь, Увс, Сүхбаатар	1,239.8
15	Бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил	Өмнөговь, Дорноговь, Баянхонгор, Дорнод	102.1
16	Өвөлжилт хүндэрсэн малчдад хүнсний тусламж	12 аймаг	1,232.2
17	Зөгийн гэр болон сэмж	Аж ахуй эрхлэгч, Хоршоо	347.4
18	Богийн арьсыг халимлах төхөөрөмж, Арьс ширний тордолтын бодис нийлүүлэх	Аж ахуй эрхлэгч, Хоршоо	142.0
	Нийт		6,362.6

Эх сурвалж: ТХН

1.46 Төсөл хэрэгжүүлэгч нэгж дээрх аж ахуйн нэгжид олгосон 18 нэр төрлийн 6.3 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэгжилт явцын талаар Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан журмын 10.3¹⁶-д заасны дагуу тайлагнаагүй байна.

Төслийн санхүүжилтээр бий болсон өмч хөрөнгө ашиглалтгүй, бүртгэлгүй байна

1.47 Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд нийт 6 аймгийн хэд хэдэн сумдад байршил сонгож ажлын байр засварлах, инженерийн хийцтэй худаг, өвс тэжээлийн агуулах, өвсний саравч, бог мал угаах ванн, борлуулалтын цэг, хүнсний ногоо хадгалах зоорины барилга байгууламж барихад нийт 29.9 сая ам.доллараас 2023 оны байдлаар 99 хувьтай санхүүжилтийг олгосон байна.

1.48 Мөн төслийн хүрээнд тариалан услалтын систем, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, үлийн цагаан оготно устгах болон мал үржүүлгийн багаж худалдан авах, малчдын сургалт мэдээллийн төв тохижуулах, бэлчээр ашиглалтын менежментийн багын эрсдэлийн сангийн дэмжлэг, худагт нарны сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилах зэрэг арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 9. Төслийн ерөнхий үзүүлэлт

Санхүүжүүлэгч байгууллага	НҮБ-ын Хөдөө аж ахуйн хөгжүүлэх олон улсын сангийн хөнгөлөлттэй зээл
Хөрөнгө санхүүжилт	9.06 сая ам.доллар
Төслийн хугацаа	2018 – 2023.09 сар
Төслийн ерөнхий зорилго, зорилт	Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг тогтвортой дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах, Засгийн газрын “Монгол мал”, “Хоршооны хөгжил” үндэсний хөтөлбөрүүдтэй нийцүүлэн төсөл хэрэгжиж буй аймгуудын малчин өрхүүд болон аймаг, сумын төвийн иргэдийн амьжиргааг дээшлүүлж ядуурлыг бууруулах
Төсөл хэрэгжих аймгууд	Архангай, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар
Төслийн бүрэлдэхүүн хэсэг	Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь Зах зээлийн хөгжил
Төслийн үр дүн	Малчин өрхийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, бичил, жижиг бизнес эрхлэгчид, ХАА-н хоршоодын иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг тогтвортой дээшлүүлнэ

Эх сурвалж: Төслийн зээлийн гэрээ

1.49 Төслийн нийт ашиглалт 2023 оны эхний улирлын байдлаар ажлын гүйцэтгэл 85 хувь, зээлийн ашиглалт 8.4 сая ам.доллар буюу 93 хувь байсан бол 3 дугаар улиралд 99 хувьд хүрснээр төсөл сүүлийн хагас жилд бүрэн хэрэгжихээр байна.

1.50 Төсөл хэрэгжүүлэхийн өмнөх төлөвлөлт, хэрэгцээ шаардлага тодорхойлсон судалгааны ажлын тайлан баримт мэдээлэл хангалтгүй, хийгдээгүй, зарим төслүүд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

1.51 Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн зарим сумдад төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэж, улмаар хөрөнгийг ашиглахгүй орхисон, засвар хийсэн барилга байгууламжийг актлах зэрэг зөрчлүүд байна. Тухайлбал:

- Өвөрхангай аймгийн Төгрөг, Хархорин, Тарагт сумдад Бог мал угаах нийт 54.8 сая төгрөгийн 7 ширхэг ванн барих ажлыг гүйцэтгээч Баяжих ундарга ХХК нь стандарт бус хэмжээгээр гүйцэтгэснээс тус байгууламж ашиглагдахгүй болжээ,
- Хархорин сумын Ганган, Орхон багт байрлах хуучин сургуулийн дотуур байрыг ажлын байр болгож засварлахад төслөөс 35.0 сая, орон нутгаас 2.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, ажлыг гүйцэтгүүлсэн ч Аймгийн ИТХ-ын 2022 оны 11/02 тоот тогтоолоор акталж, барилгыг буулган 100 ортой эмнэлэг барих ажил эхлүүлсэн байна,
- Бат-өлзий суманд барьсан хүнсний ногооны зоорийг Өндөр буянт хайрхан ХХК нь 80.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, 2022 оны өвөл тариалан эрхлэгчийн 5 тонн төмсийг хадгалалтын явцад хөлдөөж, дахин ашиглах боломжгүй болгосон ба тус хүнсний зоорь битүү чийгтсэн байдалтай, дам нуруу, дээвэр, тавиур хөгцөрсөн, хананы будаг замаск ховхорч унасан, гадна хаяавч цөмөрч, хагарсан байдалтай байна.

1.52 Захиалагч зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний гүйцэтгэлийн явц, орон нутагт хүлээлгэн өгсний дараах ашиглалт, бүртгэлийн байдалд Сангийн сайдын

¹⁶ Төсөл хэрэгжүүлэх нэгж зээлийн гэрээний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байнгын дотоод хяналт тавьж Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тайлагнана.

2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын 10.1¹⁷-д заасны дагуу хяналт хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

1.53 ХХААХҮЯ-аас зарим төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн боловч хэрэгжиж дууссан болон хэрэгжилтийн шатанд байгаа төслүүдэд зарцуулсан хөрөнгө санхүүжилт, гүйцэтгэлийн дүн мэдээ төслийн үр ашгийн талаар үнэлж дүгнээгүй байна.

1.54 Энэ нь тус яамны төсөл хариуцсан газар нэгжийн үйл ажиллагаа, хүний нөөцийн хуваарилалт, чиг үүрэг хангалтгүй, дутагдалтай, залгамж чанаргүй байгаатай холбоотой бөгөөд төслүүдийн тайлан мэдээ иж бүрэн бус, нэгтгэн дүгнэгдээгүй, судалгаа мэдээлэл муутай байгаагаас харагдаж байна.

1.55 Иймд ХХААХҮЯ-ны харьяанд гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн судалгаа, хэрэгжилт, явцын тайлан мэдээг холбогдох хууль, журмын дагуу иж бүрэн, ил тод тайлагнах, нээлттэй мэдээлэлтэй байлгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуйн төслийн хүрээнд зарим байршилд ажил зогссон, хэрэгжилтийн хувь өмнөх оны үзүүлэлтээс буурсан ч шинэ байршилд арга хэмжээ төлөвлөж байна

1.56 Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Зээлийн гэрээ”-г УИХ-аар 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан байна.

1.57 Төслийн үр дүнд хүнсний ногооны тариалан эрхлэгчдийн орлого, үйлдвэрлэлд чиглэсэн дэмжлэг болоод уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, маркетингийн үр ашгийг дээшлүүлэх замаар өрхийн жижиг хүнсний ногоо эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэхээр байна.

Хүснэгт 10. Төслийн ерөнхий үзүүлэлт

Санхүүжүүлэгч байгууллага	АХБ-ны зээл, хөнгөлөлттэй зээл + Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламж
Хөрөнгө санхүүжилт	40 сая ам.доллар зээл + 2.0 сая ам.доллар тусламж
Төслийн хугацаа	2020-2023
Төслийн ерөнхий зорилго	Услалтын системүүдийг шинээр барих, сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, борлуулалт, агуулахын дэмжлэг үзүүлэх замаар хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэн ногоочид, тариаланчдын чадавх, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах
Төсөл хэрэгжих аймгууд	ГАА-н Халиун сум, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Алтай, Баян-Өлгий аймгийн Баяннуур, Сагсай сум, Завхан аймгийн Тэлмэн, Улиастай сум, Сэлэнгэ аймгийн Сант, Төв аймгийн Батсүмбэр сум, Хэнтий аймгийн Хэрлэн сум. Шинээр нэмэх санал: Ховд аймгийн Мянгад, Хэнтий аймгийн Мөрөн сум (Төслийн Удирдах хорооны шийдвэр)
Төслийн бүрэлдэхүүн хэсэг	Эрс тэс уур амьсгалд тэсвэртэй, үр ашигтай усалгааны дэд бүтэц бий болгох -14 Уур амьсгалд тэсвэртэй газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих Чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ
Төслийн үр дүн	7,000 га усалгаатай газар тариалан 3,400 өрх (үүнээс 1,000 нь ядуу өрх) хүнсний ногооны үйлдвэрлэл 30 хүртэлх хувиар нэмэгдэнэ

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны төслийн мэдээлэл

1.58 Төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн, Халиун, Ховд аймгийн Эрдэнэбүрэн Алтай, Баян-Өлгий аймгийн Баяннуур, Сагсай, Завхан аймгийн Тэлмэн, Улиастай Сэлэнгэ аймгийн Сант, Төв аймгийн Батсүмбэр, Хэнтий аймгийн Хэрлэн сумдын нутагт услалтын систем барих сэргээн засварлах ажил хийгдэхээр байна.

¹⁷ 10.1. Төсөл, арга хэмжээний суурь нөхцөл байдал, хэрэгжилтийн явц, үйл ажиллагааны зорилт, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

1.59 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төслийн зураг төсвийг иж бүрэн боловсруулж батлаагүйгээс 9 байршилд барьж буй услалтын системийн зураг төсөв өөрчлөгдөж төсөвт өртөг 6.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэх шалтгаан болсон байна.

1.60 Мөн гүйцэтгэгч сонгон шалгаруулалттай холбоотой шүүхийн маргаанаас Завхан аймгийн Улиастай сумын услалтын системийн ажил зогссон бол нийт төслүүдийн хувьд ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлж дүгнээгүй, гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөх боломжгүй болсон нь тариалан эрхлэгч өрхийн орлогын эх үүсвэрт сөргөөр нөлөөлөхөөр байна. Тухайлбал:

- Баяннуур сумын усжуулалтын системийг шинэчлэх төсөл Баяннуур сумаас урьд зүгт 161 га талбай газрыг хамрахаар байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 68 хувьтай буюу төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй,
- Завхан аймгийн Улиастай суманд 64 га талбайг усжуулах ажлын гүйцэтгэл шүүхийн маргааны улмаас 2022 оноос хойш 30 хувийн гүйцэтгэлтэй зогссон,
- Мөн аймгийн Тэлмэн суманд 500 га талбайг усжуулах ажлын гүйцэтгэл Хүрэн талын услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажлын зураг төслийг тухайн төсөл хэрэгжих газар дээр ирж үзэхгүйгээр зургийг хийсэн нь бодит нөхцөл байдалтай нийцээгүйгээс алдаатай болсон,
- Зургийн гүйцэтгэгч байгууллагаас ажлын ерөнхий зургийг өөрчлөх саналыг холбогдох газарт хүргүүлсэн ч шийдэгдээгүй,
- Ажлын зураг төсөлд тусгагдсан бороожуулагч машинаар услах талбайн голоор Мөрөн-Улиастайг холбосон 110 кв-ын өндөр хүчдэлийн цахилгаан шугам дайран гарч байгааг зураг төсөлд тусгаагүй,
- Энэ нь бороожуулагч машиныг зураг төсөвт тусгасан талбайд суурилуулах боломжгүй байдлыг бий болгосон,
- Цахилгааны эх үүсвэрийг гэрээнд заасан газраас авах боломжгүй нөхцөл байдал үүссэн г.м
- Ховд 2022 онд Эрдэнэбүрэн суманд 2000 га услалтын системийн барилгын ажил шинээр хийгдэхээр төлөвлөгдсөн, 2023 оны 7 дугаар сард 1000 га газар болгон өөрчилсөн, одоогоор ажил эхлээгүй байна.

1.61 Салбарын яамнаас төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд 2022 оны байдлаар хийсэн ХШҮ-гээр төслийн гүйцэтгэл тухайн онд 48.0 хувьтай, өмнөх оны хэрэгжилтээс 37.5 хувиар буурсан дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

1.62 Төсөл хэрэгжүүлэхээр сонгогдсон 12 байршилд услалтын системийг шинэчлэн сайжруулснаар шинээр 7000 га талбайг услах нөхцөл бүрдэж, гэрээ байгуулсан 10 услалтын систем бүрэн ашиглалтад орсноор 3031 га талбайг услах боломжтойгоор төлөвлөгөөний 43.3 хувийг хангах нөхцөл бүрдэхээр байна.

1.63 Харин төслийн хүрээнд хэрэгжүүлэх Ховд аймгийн Эрдэнэбүрэн дэд төслийн /2000 га/, Сэлэнгэ аймгийн Охиндойн тал дэд төслийн /2670 га/ үйл ажиллагаа нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд үндэслэн зогссоноор нийт 4670 га талбайг усжуулах боломж хумигдсан байна.

1.64 Хүнсний ногооны үйлдвэрлэл, усалгаатай газар тариалан төслийн зарим байршилд хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээгүй, эхлүүлсэн ажлын явц зогсонги байдалд хүрснийг шийдвэрлэхгүйгээр услалтын системийн байгууламж барих арга хэмжээг өөр байршилд төлөвлөж байгаа нь санхүүжилтийг үр ашиггүй болгох эрсдэл үүссэн байна.

1.65 Иймд төслийн хүрээнд үргэлжлүүлэх боломжгүй зогссон Охиндойн тал дэд төслийн оронд тус төслийн үр дүн, үр өгөөжтэй дүйцэхүйц услалтын системийн байршлыг оновчтой сонгох, Ховд аймгийн Мянгад, Хэнтий аймаг Мөрөн, Сэлэнгэ аймаг Орхонтуул, Төв аймгийн Борнуур зэрэг байршилд услалтын систем барих ажлыг эхлүүлэхдээ дээрх алдааг давтахгүй, эрсдэлийг тооцон төслийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлж, зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зээлийн хөрөнгөөр гаргаж буй батлан даалтын чанарыг сайжруулах, төслийн шаардлага, шалгуурыг хангаж ажиллах шаардлагатай байна

1.66 “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх” МОН-3338 төслийн зээлийн хэлэлцээрийг 2016 онд Жижиг,

дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилт авах, бизнесийн тогтвортой байдлыг сайжруулах замаар өсөлт, эдийн засгийн төрөлжүүлэл болон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор АХБ-тай 60 сая ам.долларыг 18 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийн гэрээг байгуулсан байна.

1.67 Сангийн яам болон Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2016 оны 12 дугаар сард 58.6 сая ам.долларын дамжуулан зээлдүүлэх гэрээг 18 жилийн хугацаатай үндсэн төлбөрөөс 12 жил чөлөөлөгдөх нөхцөлтэй байгуулсан бол 2020 онд тус гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 60.0 сая ам.доллартой тэнцэх төгрөгийг 2028-2033 оны хооронд төлж дуусгахаар болсон байна.

1.68 Зээлийн батлан даалтын сан нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасны дагуу барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй иргэн, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ААН-д батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд батлан даалтын хэмжээ нь тухайн зээлийн 60 хүртэлх хувиар олгох зохицуулалттай байна.

1.69 АХБ-ны МОН-3338 төслийн хүрээнд нийт 173,216.3 сая төгрөгийн зээлд 94,641.2 сая төгрөгийн батлан даалт гаргаж үүнээс ХАА-ны салбарт үйл ажиллагаа эрхэлж ажлын байр нэмэгдүүлэх шаардлагатай 37 иргэн, ААН-ийн 14,892.5 сая төгрөгийн зээлд 8,268.6 сая төгрөгийн батлан даалт гаргаж 14 иргэн, ААН зээлээ төлж дууссан байна.

1.70 Төслийн үйл ажиллагаа явуулж зээлийн батлан даалттай 23 иргэн, ААН-ийн 9,338.5 сая төгрөгийн зээлд 5,480.1 сая төгрөгийн батлан даалт гаргажээ.

1.71 Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн хэрэгжиж буй төслийн зорилго нь банкны шалгуур хангасан боловч барьцаа хөрөнгө хангалтгүй иргэн, ААН-ийн зээлийг 60 хувь хүртэл батлан даах бөгөөд тухайн төсөл хэрэгжүүлэхээр авсан иргэн, ААН-ийн үйл ажиллагааны үр дүнг хянах, тооцох боломжгүй байна.

1.72 Зээлийн батлан даалтын сан зээлийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд тавих хяналтыг Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан журмын 7.3¹⁸, 10.3.¹⁹, 10.4.²⁰ гэж заасныг хэрэгжүүлэх боломжгүй байна.

1.73 Төслийн хүрээнд иргэн, ААН-д шаардлагатай байгаа зээлийн батлан даалт гаргаснаар ЗБДС-ийн оролцоо зогсож, арилжааны банканд зээлээ эргэн төлөх, төсөл үр дүнтэй амжилттай хэрэгжих нь ААН-ийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай болж байна.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр төслийн зааварт өөрчлөлт оруулснаар батлан даалтын хэмжээ нэмэгджээ

1.74 Зээлийн батлан даалтын сан МОН-3338 төслийн хүрээнд арилжааны банкаар дамжуулан авч буй зээлд 60 хүртэлх хувийн батлан даалт гаргаж байсан бол 2021 онд төсөл хэрэгжүүлэх зааварт Ковид-19 цар тахлын нөлөөгөөр жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээлийн нөхцөл хүндэрсэн зээлийн ашиглалт буурсантай холбоотой Сангийн яам болон АХБ-нд хандан батлан даалтын нөхцөлд дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Хүснэгт 11. Зээлийн батлан даалтын нөхцөлд оруулсан өөрчлөлт

Ангилал	Нэгж	Анхны нөхцөл	Шинэчлэгдсэн нөхцөл
Зээлийн хэмжээ	Тэрбум төгрөг	1.0	2.0
Батлан даалтын хэмжээ		0.5	1.2
Зээлийн хугацаа	Жил	10	10
Батлан даалтын хэмжээ	Хувь	30-60	30-60
Зээлийн хүү		12-15	8.88-12.34
Нэмэлт эх үүсвэр /банкны саналаар/		-	20

¹⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

¹⁹ Төсөл хэрэгжүүлэх нэгж зээлийн гэрээний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байнгын дотоод хяналт тавьж Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тайлагнана.

²⁰ Төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрийн хариуцах гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хэрэгжиж дууссаны дараа эцсийн үнэлгээ хийн харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнана.

Дахин санхүүжилтийн хэмжээ *	50	100
------------------------------	----	-----

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

1.75 МОН-3338 төслийн хүрээнд ХАА-ны салбарт үйл ажиллагаа эрхэлж ажлын байр нэмэгдүүлэх шаардлагатай 37 иргэн, ААН-ийн 14,892.5 сая төгрөгийн зээлд 8,268.6 сая төгрөгийн батлан даалт гаргаж, 4 зээлдэгчид 600.0 сая төгрөгийн 20 хувийн нэмэлт эх үүсвэр гаргасан байна. Төслийн хүрээнд зээл авч батлан даалт гаргуулсан иргэн, ААН-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Тухайлбал,

- Хөвсгөл аймагт Тулгат олз ХХК нь Төрийн банкнаас жилийн 13.76 хувийн хүүтэй 10 жилийн хугацаатай 926.0 сая төгрөгийн зээлийг Төрийн банкнаас 2021 оны 3 дугаар сарын 31-нд авч Зээлийн батлан даалтын сангаас 420.0 сая төгрөгийг батлан даасан байна. Төрийн банк, Тулгат олз ХХК хооронд байгуулсан гэрээний дагуу хүү болон үндсэн зээлийг эргэн төлөөгүйгээс 125.1 сая төгрөг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. Мөн хөргүүртэй ил зoorь 500 тн 680.0 сая төгрөг, газар дэд бүтэц байгуулах 72.5 сая төгрөгийг өртөгтэй ажлуудыг хийгээгүй, зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
- Булган аймагт “Түүчээ Намнан” ХХК, “Уран онигууд” ХХК-ууд 650.0 сая төгрөгийн зээл нь зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээнд тусгасан үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдээгүй, зогсож зээлдэгч шүүхэд шилжүүлж, шүүхийн шийдвэр гарсан байна. Мөн тус төслийн хүрээнд 1 ААН-н хэрэгжүүлсэн төсөл нь бүрэн ашиглалтад ороогүй, 2 ААН нь тус зээлийн эргэн төлөлт хийгдээгүй үйл ажиллагаа зогссон шүүхийн шийдвэр гарч ажиллагаа хийгдэж байна.
- Сэлэнгэ аймагт Гэцэлцэцүүх БГБХН нь үнээний ферм байгуулах, өргөжүүлэх зориулалтаар 100,000.0 мянган төгрөгийн зээл авч, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор фермийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй болсон гэх үндэслэлээр ААН-г худалдан борлуулж, уг хөрөнгөөр зээлийг хугацаанаас нь өмнө барагдуулсан байна.
- Өсөх буудай ХХК нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар 840,000.0 мянган төгрөгийн зээл авч, Сэлэнгэ Meat фүүдс нэртэй мал нядалгааны газрыг 2019 онд ашиглалтад оруулснаар 2022 оныг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад тус нядалгааны цехийг Тайсу Ман ХХК-д худалдан борлуулж, тус хөрөнгөөр Мандал сумын нутагт Акуа Сэ цэвэр усны үйлдвэрийг барьсан байна.

1.76 Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан МОН-3338 төслийн хүрээнд 439 зээлдэгчид 94,641.2 сая төгрөгийн батлан даалт 40 зээлдэгчид 5,270.6 сая төгрөгийн 20 хувийн нэмэлт эх үүсвэр тус тус гаргасан байна. Үүнээс 32 зээлдэгчид гаргасан батлан даалтын чанаргүй зээлийн үлдэгдэл 3,084.6 сая төгрөг байна.

1.77 Иймд зээлийн батлан даалтын чанарыг сайжруулах, зээлийн хэлэлцээр, төсөл хэрэгжүүлэх зааврын шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай байна.

Төслийн удирдах хороо байгуулаагүй, зээлийн батлан даалтын сангийн дүрмээр төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна

1.78 Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл нь Өрийн удирдлагын тухай хууль, Сангийн сайдын 2015 оны 196, 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан²¹ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зохицуулалттай.

1.79 ЗБДС МОН-3338 төсөл 2016-2021 онд Сангийн яаманд харьяалагдаж байсан бол, 2022 оноос ХХААХҮЯ-ны харьяанд шилжсэн байна.

1.80 Тус төслийн үйл ажиллагааг Сангийн сайдын тушаалаар 2019 онд ТУХ байгуулсан ч үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ХХААХҮЯ ТУХ-г шинэчлэн байгуулаагүй байна.

1.81 Төслийн үйл ажиллагааг ЗБДС байгууллагын дүрэм, удирдах зөвлөл, зээлийн батлан даалтын хорооны хурлаар үйл ажиллагаа бие даан хэрэгжүүлж ирсэн байна. Энэ нь төсөл хэрэгжүүлэх байгууллага /сан/-ын үндсэн үйл ажиллагааны онцлогтой холбоотой бөгөөд Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг

²¹ “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.6²², 7.9²³-д заасантай тус тус нийцэхгүй байна.

1.82 Мөн төслийн үйл ажиллагааны данс, ЗБДС-ийн үндсэн үйл ажиллагааны данстай нэг байгаа нь дээрх журмын 9.2.3²⁴, 9.2.27²⁵-д заасантай нийцэхгүй байна.

Зээлийн хөрөнгийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон нь эргэн төлөлт хийгдэхгүйд хүргэжээ

1.83 Монгол Улсын болон БНБУ-ын Засгийн газар хооронд 2019 онд экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрт төслийн хүрээнд нийлүүлэх техник, тоног төхөөрөмжийг татвар, хураамжаас чөлөөлөгдөхөөр заасан ба Сангийн яам /зээлдүүлэгч/, ХХААХҮЯ /дэд зээлдэгч/, ХААДС /эцсийн зээлдэгч/-гийн хооронд 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр дамжуулан зээлийн гэрээг байгуулсан байна.

1.84 Төслийн хүрээнд ХХААХҮС-ын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А-238 тоот тушаал, ХААДС-ын ажлын албаны захирлын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/147 тоот тушаалаар нийт 4 төрлийн 534 ширхэг техник, төхөөрөмжийн үнэ, олгох нөхцөлийг баталсан байна.

1.85 Худалдах үнийг нийт 4,524.0 сая евро ба үйл ажиллагааны зардлыг нэг удаа 1 хувиар тооцон нэмж, 30 хувийн урьдчилгаа төлбөртэй, үлдэгдэл төлбөрийг дараагийн 3 жилд тэнцүү хуваан төлөх нөхцөлтэй, жилийн 1.37 хувийн хүүтэй, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээ байгуулах нөхцөлүүдийг баталсан байна.

1.86 Тус гэрээний дагуу БНБУ-ын Хөгжлийн банк нь зээлийн хэлэлцээрт тусгагдсан нөхцөлийн дагуу 3,845.4 сая евротой тэнцэх хөрөнгийн эх үүсвэрийг зээлдүүлэхээр тохиролцсон ба эцсийн зээлдэгчийн зээлийн хүү болон шимтгэл жилийн 1.37 хувь, төлж барагдуулах хугацаа 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2027 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, зээлийн үндсэн хүү, шимтгэлийн төлбөрийг жил бүрийн 4 дүгээр сарын 10-ны өдөр, 10 дугаар сарын 15-ны өдөр зээлдүүлэгчид төлөхөөр заасан байна. /зээлийн төлөлтийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу/

1.87 Нийт төслийн хүрээнд 3,845.4 сая еврогийн техник, тоног төхөөрөмж оруулж ирснээс 2023 оны 8 дугаар сарын байдлаар нийт 54 ширхгийн үлдэгдэлтэй байна.

1.88 ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А-238 дугаар “Трактор техникийн худалдах үнэ, олгох нөхцөл, хуваарийг батлах тухай” тушаалын хавсралтаар нийлүүлэх хуваарийг баталсан бөгөөд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Тосонцэнгэл, Мөрөн сумдад Тосонцэнгэл сумын “Тосон тээлийн өгөөж” хоршоонд 17,935.0 евро буюу 60.3 сая төгрөг, Мөрөн сумын “Дэлгэрэх шимт” хоршоо 35,870.0 евро буюу 120.6 сая төгрөг нийт 180.9 сая төгрөгийн трактор болон бусад дагалдах хэрэгслийн хэрэгцээ шаардлага байгаагүй, нөхцөлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй шалтгаанаар худалдан авалт хийгээгүй байна.

1.89 Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжийг зөвхөн худалдах, худалдан авах гэрээгээр иргэн, ААН-д олгох нөхцөлтэй боловч Хэнтий аймгийн Хэрлэн суманд жижиг оврын 2 трактор, ургамал хамгааллын бодис цацагч, сийрүүлэгч, Мөрөн суманд анжис зэргийг буцалтгүй тусламж хэлбэрээр хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 12. Тоног төхөөрөмжийн нэр, үнийн нэгтгэсэн судалгаа

№	Техникийн нэр	Нэгж үнэ /евро/	Тоо хэмжээ	Үнэ /евро/	
				Урьдчилгаа	Үлдэгдэл
1	Трактор 320.4	12,100.00	1	-	12,100.0

²² Журмын 7.6 Төсөл хэрэгжүүлэх нэгж нь зээлийн гэрээ болон батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төсөл, арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төсвийн тухай хуулийн 17.1-д заасан этгээд байна

²³ Журмын 7.9 Төслийн зохицуулагч нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах Төсвийн тухай хуулийн 16.4.16-д заасан этгээд байна”

²⁴ Журмын 9.2.3.Зээлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол төсөл, арга хэмжээний тусгай данс, дэд дансыг төрийн санд, тэг үлдэгдэлтэй валютын дансыг арилжааны банканд нээнэ.

²⁵ Журмын 9.2.27. Зээлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол төсөл, арга хэмжээний тусгай болон дэд дансанд хуримтлагдсан хүүг сар бүр улсын төсөвт төвлөрүүлнэ.

2	Ургамал хамгааллын бодис цацагч	1,600.00	2	-	1,600.0
3	Сийрүүлэгч манагч	4,235.00	2	-	4,235.0
4	Анжис	2,428.00	1	-	2,428.0
Нийт					20,363.0

Эх сурвалж: ТХН

1.90 Зээлийн эргэн төлөлт хийгдээгүй нь Өрийн удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2²⁶-т заасны дагуу эцсийн хэрэглэгчтэй гэрээ байгуулаагүй, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5²⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

1.91 Дээрх нөхцөл байдалтай холбоотой тус сумдын ЗДТГ-аас тоног төхөөрөмжийн зээлийн гэрээ байгуулсан ч эргэн төлөлт хийх боломжгүй талаар 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 2/555 тоот албан бичгээр аудитад ирүүлсэн тул ХААДС-нд буцаан татан төвлөрүүлж борлуулан зээлийн хөрөнгийн эргэн төлөлтөд үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс тус зөрчлийн арилгах албан шаардлагыг өгөхөөр төлөвлөсөн болно.

Барилга угсралтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн

1.92 Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн буцалтгүй тусламжийн 3.5 сая ам.долларын “МОН 50278” гэрээг Монгол Улс болон Япон улсын засгийн газар хооронд 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан ба 2019 онд нэмэлт хэлэлцээр хийж 500.0 мянган ам.долларын санхүүжилтийг өндөр технологит дөрвөн улирлын хүлэмжийг барих зорилгоор байгуулсан байна.

1.93 Төсөл нь 2017-2021 оны хооронд Сэлэнгэ аймгийн Ерөө, Дархан-Уул аймгийн Орхон, Төв аймгийн Борнуур, Увс аймгийн Улаангом сумдад хэрэгжихээр төлөвлөсөн боловч цар тахал, хил гаалийн хорио цээр, үнийн өсөлттэй холбоотой асуудлаас шалтгаалж 2023 оныг дуустал сунгагдсан байна.

1.89 Буцалтгүй тусламжийн хүрээнд ХХААХҮЯ-наас худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2022 оны 05 дугаар сарын 01/1587 тоот гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүргүүлж “Агро-Альфа” ХХК-тай байгуулсан 1.148.0 сая төгрөгийн өртөгтэй “Улаанбаатар хотод 800м² дэвшилтэт технологийн өвлийн хүлэмж барих” төслийн гэрээг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан ба ажлын явц 80 хувь, санхүүжилтийн дүн 803.6 сая төгрөг байна.

1.90 Тус хүлэмжийн барилгыг БНХАУ-ын Кингфенг компанийн зураг төслийн дагуу гүйцэтгэсэн бөгөөд барилга угсралтын ажил эхлэх зөвшөөрөл, магадлалын дүгнэлтгүй, захиалагчийн хяналт хийгдээгүй, газрын зөвшөөрөл 2023 оны 8 дугаар сард гарсан зэрэг алдаа зөрчил илэрлээ.

1.91 Энэ нь барилга байгууламжийн зураг төслийг гадаадын эрх бүхий хуулийн этгээд боловсруулсан ч Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6²⁸-дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.2.1²⁹-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Дүрслэл 6. Өвлийн хүлэмжийн суурь болон шилэн фасадын каркас угсарсан байдал

²⁶ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчтэй байгуулсан дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг үндэслэн зээлийн хөрөнгийг олгоно.

²⁷ Орон нутгийн төсөвт Өрийн удирдлагын тухай хууль болон энэ хуулийн 41.5, 57.4, 62.2-т зааснаас бусад тохиолдолд өр үүсгэх, баталгаа гаргахыг хорилоно.

23.6. Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийг баталгаажуулахад тавих шаардлагыг энэ хуулийн 32.1.8-д заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэмд тусгана.

²⁹ 25.2.1.газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт;



1.92 Цаашид барилгын ажил эхлэх зөвшөөрөл, магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэж Барилгын тухай хууль, норм дүрмийг мөрдөж ажиллах талаар эрх бүхий этгээдэд албан шаардлага хүргүүлэхээр аудитын баг шийдвэрлэв.

Зээлийн хөрөнгийг тусламж хэлбэрээр тооцоо судалгаагүй, үр дүн нь тодорхой бус арга хэмжээнд зарцуулсан байна

1.89 Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд Мал аж ахуйн эдийн засгийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 6508MN тоот дугаартай 30.0 сая ам.долларын санхүүжилтийн хэлэлцээрийн хүрээнд Сангийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 55 дугаар тушаалаар ТХН-ийг байгуулжээ.

1.90 Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А-100 дугаар тушаалаар Төслийн Удирдах хороог байгуулсан ба “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн үйл ажиллагааг 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс эхлүүлсэн байна.

1.91 Төслийн бүрэлдэхүүнд болзошгүй онцгой байдал, гамшгийн үед хариу арга хэмжээ авахад дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Хүснэгт 13. Төслийн бүрэлдэхүүний хуваарийн өөрчлөлт сая.ам доллар

Бүрэлдэхүүн хэсэг	Батлагдсан	Шинэчлэгдсэн	Өөрчлөлт
Малын эрүүл мэнд	20.0	8.5	-11.5
Өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлт	8.0	6.5	-1.5
Төслийн хэрэгжилтийг дэмжих	2.0	2.0	-
Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ	-	13.0	+13.0
Нийт	30.0	30.0	-

Эх сурвалж: ТХН зээлийн санхүүжилтийн хуваарийн өөрчлөлт

1.92 Засгийн газраас ХАА-н салбарын 2020-2021 оны өвөлжилт хүндрэх нөхцөл байдал үүссэнтэй холбоотой өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй аймаг орон нутгийн малчид, ард иргэдийг гамшгийн эрдлээс хамгаалах эрсдэл багатай даван туулахад зарцуулах зорилгоор тэжээл, мөнгөн тусламж олгох шаардлага үүссэн гэх үндэслэлээр дараах тогтоол шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 213 дугаар тогтоолоор 5.0 сая ам.доллар,
- Засгийн газрын 2021 оны 110 дугаар тогтоолоор 8.0 сая ам.доллар нийт 13.0 сая ам.доллар

1.93 Дээрх шийдвэр нь нэг талаас байгалийн болзошгүй хүндрэлээс үүсэх эрсдэлээс малчид, ард иргэдэд учирч болох эрсдэлийг буруулсан хэдий ч нөгөө талаас малын эрүүл мэндийн үйлчилгээ, малын өвчний тандалт, урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээний тоог цөөрүүлж, хэрэгжилтийг зогсоосноор малын эрүүл мэндийг сайжруулах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлийн төслийн үндсэн зорилт хангагдахгүй байх, төлөвлөгөөт ажлууд орхигдох удаашрах сөрөг нөлөөтэй болсон байна. Тухайлбал,

- Төслийн анхны баримт бичигт буюу дээрх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 14 аймгийн 150 суманд хэрэгжүүлэхээр тусгагдсаныг 12 аймгийн 80 сум болгож, 3 бүсийн 2 аймгийн 5 нийт 10 байршилд магадлан итгэмжлэгдсэн мал эмнэлгийн лаборатори байгуулахаар тусгасан

боловч төслийн баримт бичигт өөрчлөлт оруулснаар лабораторийн тоог 2 болгон цөөрүүлсэн байна.

1.94 Мөн улсын хэмжээнд хаваржилтын хүндрэлийг даван туулах, нөхөн сэргээхэд нийт 181000 малчин өрх тус бүрд 100 000 төгрөг нийт 18.0 тэрбум төгрөг тараах арга хэмжээний хүрээнд 179 849 өрхөд 17.8 тэрбум төгрөгийг тараасан боловч салбарын яам болон ТХН-ээс холбогдох хяналт хэрэгжүүлээгүй, зээлийн хөрөнгийг тусламж хэлбэрээр тооцоо судалгаагүй, үр дүн нь тодорхой бус арга хэмжээнд зарцуулсан байна.

1.95 Мөн төслийн болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээнд зарцуулах бүрэлдэхүүн хэсгийн хөрөнгийн 1.6 сая ам.доллараар төвийн болон баруун бүсэд малын тэжээлийн үйлдвэр байгуулах арга хэмжээний сонгон шалгаруулалт удааширсантай холбоотой уг ажил эхлээгүй байгаа нь төслөөс бий болох үр дүн хойшлогдох зорилт хангагдахгүй байх эрсдэл үүссэн байна.

1.96 Иймд цаашид төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний санхүүжилтэд тооцоо судалгаагүй өөрчлөлт оруулахгүй байх, зээлийн гэрээний хугацаанд бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрэн хэрэгжүүлж дуусгах, холбогдох хяналтыг хэрэгжүүлж төслийн бодит үр дүнг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээг ХХААХҮЯ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Экспортыг дэмжих төслийн гадаад болон дотоод зөвлөхийн зардал нь нийт зардлын 44.2 хувийг эзэлж байна

1.97 Экспортыг дэмжих төслийн удирдах хороог ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/211 тушаалаар, Сангийн сайдын 2020 оны 53 дугаар тушаалаар ТХН-ийн бүтэц, орон тоог баталж, уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготойгоор 2016-2019 онд Сангийн яамны дэргэд, 2020 оноос эхлэн ХХААХҮЯ руу шилжиж 2023 оныг дуустал хэрэгжихээр байна.

1.98 Төслийг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр нийт 20.0 сая ам.доллараар 4 бүрэлдэхүүний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Дүрслэл 7. Төслийн бүтэц, бүрэлдэхүүн



1.99 Төслийн хувьд Монгол Улсын уул уурхайн бус салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилго болон бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог авч үзэхэд дэд хэсгүүдийн үйл ажиллагаа нь бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаагаа дэмжсэн, бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа нь төслийн зорилгоо биелүүлэхэд дэмжлэг болж хоорондоо уялдаатай байна.

1.100 Экспортыг дэмжих төсөл хөтөлбөр нь дараах байдлаар бүтэц зохион байгуулалт 2 удаа, төслийн арга зүйг 4 удаа өөрчилсөн байна.

Дүрслэл 8. Хөтөлбөрийн өнөөдрийг хүртэлх бүтцийн өөрчлөлт



Эх үүсвэр. ТХН

1.101 Төслийн нэгж нь 20 сая ам.долларын санхүүжилт авснаас 2023 оны 09 дүгээр сарын 14-ний байдлаар 9.9 сая ам.доллар буюу 29.5 тэрбум төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Хүснэгт 14. Төслийн нээжийн зарцуулалт задаргаа сая.төгрөг

№	Бүрэлдэхүүн хэсэг	Дэд бүрэлдэхүүн хэсэг	Гэрээний дүн	Гэрээний гүйцэтгэл	Үлдэгдэл төлбөр
1	Сангийн яамны харьяа 2016-2019 онд 3 бүрэлдэхүүн хэсэгт зарцуулалт		5,035	5,035	-
2	1: Экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх		1,172	956	216
3	2: Экспортын өрсөлдөх чадвар, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх	2.1. Худалдаа, экспортын бодлого зохицуулалт, чадавх сайжруулах	4,308	3,879	430
		2.2. Олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадварыг сайжруулах	2,657	1,139	1,519
		2.3. Түншлэлийн хөтөлбөр	17,570	5,170	12,400
		2.4. ААН-дэд цар тахлын хүндрэлийг даван туулахад үзүүлэх санхүүгийн дэмжлэг	4,274	4,274	-
4	3: Баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах		6,468	6,123	345
5	4: Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх		4,110	2,951	1,159
Нийт дүн			45,594	29,527	16,069

Эх сурвалж: ТХН

1.102 Экспортыг дэмжих төсөл нь 2016-2019 оны хооронд Сангийн яамны харьяа хэрэгжиж 5,035.0 төгрөгийн зарцуулалт хийж, Түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд 76 ААН-тэй гэрээ байгуулан ажилласан бол 2020-2023 оны хооронд 131 ААН-тэй гэрээ байгуулж үүнээс ХАА-ын салбарын чиглэлээр 44 ААН-тэй 6,506.0 сая төгрөгийн гэрээ байгуулж 1,762.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг өгсөн байна.

1.103 Төслийн нэгжийн түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд 2020-2023 оны ХАА-ын салбарт 44 ААН төлөвлөгөө, гэрээний гүйцэтгэл хангалтгүйгээс 72.9 хувь буюу 4,744.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээ аваагүй байна. /Хавсралтаар ААН-ийн санхүүгийн дэмжлэгийг харуулав/

1.104 Түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд 44 ААН-ээс 38 ААН экспортод бүтээгдэхүүний гаргасан ба дараах 6 ААН экспортод бүтээгдэхүүн гаргаагүй байна. Үүнд:

- Илэнхэн ХХК
- Их халбагант
- Баяндэлгэр хүнс ХХК

- Капрадоро спининг ХХК
- Бүүвэй Кашемир ХХК, Санширо ХХК
- Хөх Үүр Тур ХХК тус тус байна.

1.105 Экспортод бүтээгдэхүүнээ гаргаагүй 6 ААН түншлэлийн хөтөлбөрт 404.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, төслөөс 188.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

1.106 Төслөөс 2-3 удаа 5 ААН 1,154.0 сая төгрөгийн гэрээ хийж 666.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зааварт санхүүгийн дэмжлэг хүртэгчид хөтөлбөрт дахин хамрагдах тохиолдолд өмнөх гэрээнд тусгагдсан үйл ажиллагааг гүйцэтгэсэн байх шаардлагатай гэсэн заалтыг ТХН болон ТУХ зөрчсөн байна.

1.107 Энэ нь ТХН болон ТУХ-нь хууль тогтоомжоор зохицуулсан эрх хэмжээнээс нэг ААН-д хэтрүүлэн эрх олгосон гэж үзэх үндэслэл үүссэн байна.

Хүснэгт 15. Нэг ба түүнээс дээш санхүүжилт авсан ААН /сая.төг/


№	ААН нэрс	Хамрагдсан он	Үйл ажиллагааны чиглэл	Гэрээний дүн	Санхүүгийн дэмжлэг авсан	Гэрээний үлдэгдэл төлбөр
1	Гоёл кашмер ХХК	2020-2023	Ноолууран эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	49.2	33.9	15.4
2	Гоёл Кашмер ХХК	2020-2023		264.0	84.0	180.0
3	Гоёл Кашмер ХХК	2016-2019		123.0	67.4	55.6
4	Монос косметик ХХК	2020-2023	Газар тариалан, хөдөө аж ахуй	83.3	10.9	72.4
5	Монос косметик ХХК	2016-2019		85.9	26.1	59.8
6	МЧГА ХХК	2020-2023	Ноолууран хувцас үйлдвэрлэл	17.6	10.3	7.4
7	МЧГА ХХК	2016-2019		9.9	5.8	4.1
8	НансКашмер ХХК	2016-2019	Ноолууран эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	76.8	59.6	17.2
9	Нанскашмер ХХК	2020-2023		60.0	10.0	50.0
10	Очир Дагинас ХХК	2020-2023	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	300.0	300.0	-
11	Очирдагинас ХХК	2016-2019		84.5	58.6	25.9
Нийт				1,154.3	666.5	487.8

Эх сурвалж: Аудитын баг

1.108 УИХ-ын 2020 оны 04 сарын 09-ний өдрийн “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газраас COVID-19-ийн хямралыг даван туулахад чиглэсэн арга хэмжээг зорилгоор 1.5 сая ам.доллар буюу 4,274.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 332 ААН-д олгосон байна. /төслийн нэгжийн мэдээллийг ашиглав/.

1.109 Төслийн нэгжийн санхүүжилтийн зарцуулалтын задаргааг харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 9. Төслийн зарцуулалт задаргаа он, төрөл бүрээр сая.төгрөг



Эх сурвалж: ТХН

1.110 Төслийн нэгж 2020-2023 онд олон улсын 9 зөвлөх 10,778.0 сая төгрөг, дотоодын 74 зөвлөх 4,809.5 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулснаас 12,836.7 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд энэ нь төслийн нийт зардлын 44.2 хувийг эзэлж байна.

1.111 Төслийн нэгжид бие даасан зөвлөх хувь хүн ажиллуулахыг хууль, дүрэм журмаар хориглоогүй ч төслийн нийт зардалд эзлэх хувь хэмжээ өндөр, төслийн гол бүрэлдэхүүн хэсэг болох түншлэлийн хөтөлбөрөөс 2.5 дахин их байна.

1.112 Экспортыг дэмжих төслийн нэгжийн 2020-2023 оны НДШ-ийн тайланг тулган баталгаажуулахад дотоод болон гадаад зөвлөхийн цалингийн зардал дээр НДШ төлөөгүй нь ажил олгогчоос 962.9 сая төгрөг, даатгуулагчаас 885.9 сая төгрөгийг алдагдсан боломжийн өртөг гарсан байна. Мөн “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 6.3, 7, 8 дугаар зүйлийг дагаж мөрдөөгүйгээс 770.3 сая төгрөгийн алдагдсан боломжийн өртөг гарсан байна. Аудитын баг албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.113 Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-нд хөлсөөр ажиллах гэрээний талаар 8.1³⁰, 8.2³¹ тус тус заажээ.

1.114 Дээрх журмын 8.21, 8.22-т хөлсөөр ажиллах гэрээт ажилтанд амрах эрх үүсэх, амралтын олговрыг тооцох тухай зохицуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3³²-т заасан тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцүүлээгүй, захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлага хангагдаагүй байна.

1.115 Түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан 131 ААН-ийн тоон мэдээллийг Гаалийн ерөнхий газрын мэдээллийн сангаас шүүж үзэхэд 78 ААН-ийн мэдээлэл бүртгэлтэй, 53 ААН экспортод бараа, бүтээгдэхүүн гаргаагүй гэж үзэхээр байна. /Хавсралт 2-оор ААН байгууллагын Экспортын тоон мэдээлэл харуулав/.

1.116 Түншлэлийн хөтөлбөрийн туршлага, сургамж” хяналт, шинжилгээ, үнэлгээний аргаар төслийн үр дүнг үндсэн 6, завсрын 6 нийт 12 үзүүлэлтээр 2020 оны тоон мэдээллийг суурь үзүүлэлт болгон тооцож үнэлэхэд дараах үр дүн гарч байна.

- Төслийн үр шим хүртээгчдийн экспортын өсөлтийн хувь 2021 онд төсөлд хамрагдсан ААН-ийн экспортын нийт орлого 97.2 сая доллар буюу 276.9 тэрбум, суурь онтой харьцуулахад 74.9 хувиар өссөн нь 2021 онд төслийн зорилго биелсэн, 2022 онд төсөлд хамрагдсан ААН-ийн экспортын нийт орлого 106.3 сая доллар буюу 334.6 тэрбум суурь үзүүлэлттэй харьцуулахад 111.3 хувиар өсөж зорилго биелсэн, 2023 оны 8 сарын байдлаар төсөлд хамрагдсан ААН-ийн экспортын нийт орлого 276 сая доллар буюу 276 тэрбум суурь онтой харьцуулахад 74.3 хувиар өсөж, төслийн зорилго биелсэн байна.
- Төслийн дэмжлэгтэйгээр олон улсын чанарын баталгаажуулалтын гэрчилгээ авсан ААН-ийн тоо 2023 оны байдлаар 11 байсан ба үүнээс 6 ААН нь эмэгтэй захиралтай байна.
- ҮДД ХК -ийн хөгжүүлсэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүний тоо шалгуур үзүүлэлт 4-ийн хувьд экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэн зах зээлд нэвтрүүлсэн байна.

1.117 Дэлхийн банк, ХХААХҮЯ хамтран баталсан Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлэх заавар, арга зүйн 6.1-т заасан шалгуур үзүүлэлтэд жилийн борлуулалтын орлогыг дунд ангилалд 50 сая евро, жижиг ангилалд 10 сая евро төгрөг, бичил ангилалд 2 сая евро

³⁰ “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан болон бие даасан зөвлөхтэй Иргэний хуулийн холбогдох зүйл заалтыг үндэслэн энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу хөлсөөр ажиллах гэрээ байгуулна”

³¹ “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудтай зөвхөн хөлсөөр ажиллах гэрээ байгуулах бөгөөд хэрэв өөр төрлийн гэрээ байгуулсан тохиолдолд уг гэрээг төсөл, арга хэмжээний хөрөнгөөр санхүүжүүлэхгүй”

³² Хуулийн 41.3.Ажил олгогч, ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 4.1.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно. Хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулсан боловч уг харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжийг агуулсан бол түүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцно.

ангилсан нь ЖДҮ-г дэмжих тухай хуулийн 4.1.1³³ заалттай нийцэхгүй борлуулалтын орлогыг өндрөөр ангилсан байна.

1.118 Төслийн сонгон шалгаруулалтад оролцох ААН-ын жилийн борлуулалтын орлогын хэмжээг өндрөөр тогтоож өнөөгийн ханшаар 184.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогоор хязгаарласан нь томоохон ААН-д хамрагдах боломжийг бий болгож, дунд, жижиг, бичил бизнес эрхлэгчдийн өрсөлдөх боломжийг хязгаарласан байна.

ААН нь зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж, зээлийн эргэн төлөлтөөр төслийг дахин санхүүжүүлж байна

1.119 Монгол улсын Засгийн газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк (ЯОУХАБ)-ны хооронд 2006 оны 6-р сарын 28-нд “ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл”-ийн зээлийн хэлэлцээр байгуулж төслийн 1 дүгээр үе шатыг /МОН-П7/ 2007-2010 онд 25.0 сая ам.долларын, 2 дугаар үе шатыг /МОН-П9/ 2011-2015 онд 60.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж эхэлжээ.

1.120 Төслийн зорилго нь ЖДҮ-ийг урт хугацааны, хүү багатай зээлээр дэмжих, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн зээлийн дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж арилжааны банкаар дамжуулан 968 ЖДҮ эрхлэгчдэд 357.3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт 16. ЖДҮ дамжуулан зээлийн мэдээлэл

№	Банк	Төслийн тоо	Зээлийн дүн
1	Хаан банк	266	90,523.0
2	Голомт банк	171	54,428.0
3	Худалдаа хөгжлийн банк	165	67,562.0
4	Капитрон банк	112	41,915.0
5	Хас банк	106	34,295.0
6	Төрийн банк	98	46,098.0
7	Бусад	50	22,497.0
	Нийт	968	357,318.0

Эх сурвалж: ТХН

1.121 Төслийн үйл ажиллагааг анх эхэлсэн цагаас нь Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан хариуцан хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2006-2017 он хүртэл Төслийн нэгжийг ЖАЙКА-аас санхүүжүүлж байсан бол 2017 оноос Сангийн яам, 2019 оноос ХХААХҮЯ-ны дэргэд үйл ажиллагаагаа явуулсан байна.

1.122 Төслийн санхүүжүүлэгч “ЖАЙКА” төслийн үр дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэсэн бөгөөд зээлийн эх үүсвэрийг 2015 онд бүрэн ашиглаж арилжааны банкнуудын дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс эргэлтийн сан бүрдүүлж, 2023 оны байдлаар үргэлжлүүлэн ЖДҮ-ийн зээлийн эх үүсвэр болгож дахин зээл олгож байна.


³³ “жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг.

БҮЛЭГ 2 ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУР ХАНГААГҮЙ, ЗУРАГ ТӨСӨВ, ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ТООЦОО СУДАЛГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний ашиглалт хангалтгүйгээс үр өгөөж тооцох боломжгүй

2.1 Засгийн газрын шугамаар хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр 213.7 сая.ам доллар, 3.8 сая евро, 5.0 тэрбум иений гэрээ байгуулснаас 2016-2023 оны байдлаар нийт зээл, тусламжийн 835.8 тэрбум төгрөгийн зарцуулалтын 657.3 тэрбум төгрөгийг арилжааны банкаар дамжуулан олгож, 178.6 тэрбум төгрөгийг Төсөл хариуцсан нэгжээр дамжин төслийн гүйцэтгэлд зарцуулагдсан байна.

Дүрслэл 10. Нийт санхүүжилтийн мэдээлэл



2.2 Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох” төслийн 171,439.8 сая төгрөг, ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл”-ийн 357,318.0 сая төгрөг, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төслийн 128,776.2 сая төгрөгийг тус тус дамжуулан зээлсэн байна.


2.3 Дээрх дүнд аудитын тайлангийн 1.20 дахь хэсэгт үзүүлсэн зээлийн ашиглалтын нийт дүнд “ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл”-ийн дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс дахин санхүүжүүлсэн 282.6 тэрбум төгрөг, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн 22.0 тэрбум төгрөгийг оруулаагүй болно.

2.4 Дамжуулан зээлсэн хөрөнгийн ашиглалт, үйл ажиллагаатай холбоотой хяналтыг аудитын хамрах хүрээнд байхгүй байсан учир хамруулаагүй болно.

2.5 Хөдөө аж ахуйн салбарын төсөл хариуцсан нэгж 2016-2023 оны хагас жилийн хооронд 178.6 тэрбум төгрөгийг зарцуулсан ба зээл, тусламжийн гүйцэтгэлийг ангиллаар тоног төхөөрөмжид 33.9 тэрбум төгрөг, барилга байгууламжид 46.8 тэрбум, сургалтад 6.9 тэрбум төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 32.1 тэрбум төгрөг, дэмжлэг тусалцаанд 29.1 тэрбум төгрөг, ТХН-ийн үйл ажиллагааны зардалд 13.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2.6 ТХН-ийн зарцуулсан зардлыг ангилж харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 11. ХАА-н салбарын зээл, тусламжийн зарцуулалтын хувь хэмжээ



Эх сурвалж: Аудитын баг

2.7 Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төслийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ нь малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ЖДҮ-г дэмжих, мэдээлэл, мэдлэгийг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, усжуулалтын систем, худаг, усны асуудал шийдвэрлэх, жижиг байгууламж барих, МАА, газар тариалангийн тоног төхөөрөмж нийлүүлэх, зөвлөх үйлчилгээнд голчлон чиглэж байна.

Тусламжаар бий болгосон хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна

2.8 Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 м² өвлийн хүлэмж барих ажлын худалдан авах ажиллагааг 2020 онд ХХААХҮЯ-аас зохион байгуулж Мандал өргөө голомт ХХК гүйцэтгэгчээр сонгон шалгарч 229.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Дүрслэл 12. Өвлийн хүлэмжийн гадна, дотор талаас /Ерөө сум/



2.9 Гэрээний дагуу өвлийн хүлэмжийн барилгын ажлыг 2021 оны 08 дугаар сард дуусган хүлээлгэн өгч тухайн сараас эхлэн тариалалт хийсэн боловч 2021 оны 11 сараас хөрсөнд хөлдөлт явагдаж өвлийн улиралд ашиглах боломжгүй болсноор тариалалт зогсож, хүлэмжийн барилга ашиглалтгүй болжээ.

2.10 Мөн Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 100 тонны багтаамжтай хүнсний ногооны агуулах барих” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022 онд ХХААХҮЯ зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Грийтволл Ковер” ХХК-ийг сонгон шалгаруулан 49.3 сая төгрөгөөр гэрээ байгуулсныг 2023 оны 3 дугаар сард ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч ашиглалтад өгсний дараа хүчтэй борооны улмаас агааржуулалтын хоолойгоор ус орсноор доторх чийгшил нэмэгдэн, цахилгааны гэмтэл гарч, гэмтлийг засварлалат зоорийг ашиглах боломжгүй болсон байна. /Аудитын баг албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв/

Дүрслэл 13. Зоорины гадна тал /Ерөө сум/



2.11 Тухайн барилга байгууламжийн чанарт Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5-д “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах”-гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.12 Дээрх үүссэн нөхцөл байдлаас үзэхэд газар тариалангийн салбар байгаль, цаг уурын байдлаас ихээхэн хамааралтай бөгөөд өвөл, зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлэх чиглэлд барилга байгууламж барих суурь судалгааны дүгнэлтэд үндэслэн

норм, дүрмийн дагуу гүйцэтгэх нь тусламжийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхээр байна.

2.13 Барилгыг ашиглалтад оруулах, шаардлага хангуулах талаар арга хэмжээ авч гүйцэтгэгчээр засварлуулж, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах талаар хариуцсан албан тушаалтанд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.14 Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөгөөгүйгээс шалтгаалж 909-МОН гэрээний зарцуулагдаагүй үлдэгдэл 335.5 мянган ам.доллар, 0684 МОН гэрээний зарцуулагдаагүй үлдэгдэл 105.3 мянган ам.доллар нийт 440.8 мянган ам.доллар байна. Иймд тусламжийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр дүнтэй ашиглах нь зүйтэй байна.

Зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн ил тод байдал хангагдахгүй байна

2.15 Гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн үйл ажиллагаа Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журам, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмаар тус тус зохицуулж байна.

2.16 Гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг дээшлүүлэх, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, төслийн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан” цахим систем (www.odamis.mof.gov.mn) нэвтрүүлсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.

2.17 Салбарын яамнаас 2021 онд Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж тайлан дүгнэлт гаргасан ч зээлийн хөрөнгөөр санхүүжсэн техник туслалцаа, тоног төхөөрөмж, хүнсний туслалцааны үр дүнг тооцоогүй байна.

2.18 Яамны зүгээс Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх 26.3³⁴-д заасныг хэрэгжүүлж ажилладаггүй байна.

2.19 Иймд зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа эргэн төлөгдөх нөхцөлгүй техник туслалцааны ашиглалт, үр өгөөжийн хяналтыг хийж үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

2.20 Энэ нь Сангийн сайдын 04-р тушаалаар баталсан журмын 13.2³⁵-т заасан төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүжилтийн эрх нээх, нэгдсэн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийн явцад хяналт тавих, үнэлэх, тайлагнах, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан, бие даасан зөвлөхийн гэрээний үүргийн биелэлт, зөрчилтэй холбоотой хяналтын бүртгэл хөтлөх үйл ажиллагааг хариуцсан эзэнгүй орхигдсон гэж үзэхээр байна.

³⁴ Үр нөлөөний үнэлгээ хийлгэх ажлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулах бөгөөд үнэлгээний тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна.

³⁵ Журмын 13.2. Гадаадын зээлийн нэгдсэн мэдээллийн сан нь цахим системийн бүрэлдэхүүн байх бөгөөд гадаад зээлийн төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүжилтийн эрх нээх, нэгдсэн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийн явцад хяналт тавих, үнэлэх, тайлагнах, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан, бие даасан зөвлөхийн гэрээний үүргийн биелэлт, зөрчилтэй холбоотой хяналтын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаа хамаарна.

2.21 Тус яамны санхүү хөрөнгө оруулалтын газар болон хөтөлбөр, төслийн бүртгэл, санхүүжилтийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төсөв, санхүүгийн уялдаа холбоог хангаагүй, зохицуулаагүй;
- Салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэлд туссан төслийн дүн шинжилгээ, үр дүнг тооцоогүй, хяналт тавиагүй;
- Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн судалгааг нэгтгээгүй, үр дүнг тооцоогүй, худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, мэдээллийг нэгтгэж ажиллаагүй;
- Төсөл хөтөлбөр хариуцсан орон тооны мэргэжилтнийг томилоогүй.

2.22 Төсөл хэрэгжүүлэх нэгж зээлийн гэрээний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байнгын дотоод хяналт тавьж Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тайлагнах үүргийг хүлээсэн байх боловч хэрэгжилт хангагдахгүй байна.

2.23 Салбарын хэмжээнд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, дүгнэлт зөвлөмжийг хэлэлцэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч биелэлтэд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангах, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж үйл ажиллагааг чанартай болгож төлөвшүүлэх шаардлагатай байна.

2.24 Мөн гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд тухайн төрийн байгууллага, ХААГ-н оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх, энэ талаар холбогдох журамд өөрчлөлт оруулах замаар зээл, тусламжийн ашиглалтад тавих хяналтын тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

2.25 Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, барилга байгууламжийн ажил, тоног төхөөрөмжүүдийг ашиглагч байгууллагууд Өрийн удирдлагын тухай хуулийн 24.5³⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4³⁷-д заасны дагуу зээл, тусламжаар хүлээн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах үүрэгтэй байна.

2.26 Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тогтоолоор “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-д зааснаар төслийн үйл ажиллагааны хэрэгжилт болон санхүүжилтийн зарцуулалтын мэдээлэл, хяналт-шинжилгээний тайлан, төсөл хэрэгжиж дууссаны дараа хийгдэх төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, төслийн эцсийн тайланг оруулахаар тусгажээ.

2.27 Гэтэл зарим аймаг орон нутагт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн санхүүжилт, тайлан бүртгэлийн дүн мэдээлэл зөрүүтэй аудитын явцад олон дахин өөрчлөгдөж залруулга хийгдэж байгаа нь нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлж дүгнэлт өгөхөд хүндрэл үүсгэж байна.

2.28 Энэ нь Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3³⁸ дахь хэсгийг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

³⁶ Энэ хуулийн 24.1.1-д заасан төсөл хэрэгжүүлэх гэрээний хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль[7]-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэнэ

³⁷ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. ... 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага...

³⁸ ТЭЗ, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.29 Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1³⁹-д, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁴⁰, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2⁴¹-т заасан чиг үүргийн хэрэгжилт хангагдаагүй зээлийн мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлүүд байна. Тухайлбал:

- Архангай аймагт Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилтийн төслийн хүрээнд 2019-2022 онд 12 төрлийн 2,634.0 сая төгрөгийн 118 арга хэмжээ хэрэгжсэнээс 6.6 хувь буюу 174.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй;
- Мөн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2018 онд 82%, 2019 онд 59%, 2020 онд 67.6%, 2021 онд 92.1%, 2022 онд 89.9%-тай буюу хангалтгүй;
- Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газарт бүртгэлтэй байгаа 218.6 сая төгрөгийн 16 ширхэг мал угаалгын ванн, Арбулаг, Баянзүрх, Их Уул, Галт, Жаргал, Төмөр булаг, Эрдэнэбулган суманд 110.2 сая төгрөгийн арьс шир боловсруулах тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн авсан гэснээр санхүүгийн тайлан бүртгэлд тусгасан боловч төслийн эх үүсвэр нь тодорхойгүй;
- Их-Уул сумын ЗДТГ-т 27.1 сая төгрөгийн 1 ширхэг, Цагаан-Уул сумын ЗДТГ-т 154.0 сая төгрөгийн 17 ширхэг, Бүрэнтогтох сумын ЗДТГ-т 192.9 сая төгрөгийн 18 ширхэг, Цэцэрлэг сумын ЗДТГ-т 109.1 сая төгрөгийн 16 ширхэг нийт 483.1 сая төгрөгийн 52 үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахаас Бүрэнтогтох сумын ЗДТГ 19.9 сая төгрөгийн 1 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй;
- Төв аймаг дахь Жигд хүч ХХК зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлснээр 4,752.6 сая төгрөгийн сүү, сүүн бүтээгдэхүүн, 776.7 сая төгрөгийн ногоон тэжээлийн борлуулалтын орлогыг 2019-2022 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд тайлагнасан;
- Жигд хүч ХХК зээлийн хөрөнгөөр 2019 онд барилга байгууламж 379.5 сая төгрөг, ХАА-н машин техник 107.2 сая төгрөг, 2020 онд барилга байгууламж 106,388.5 мянган төгрөг, ХАА-н машин техникт 359.5 сая төгрөг, 2021 онд барилга байгууламж 31.2 сая төгрөг, ХАА-н машин техник 173.1 сая төгрөг, 2022 онд барилга байгууламжид 35.0 сая төгрөг, ХАА-н машин техникт 82.1 сая төгрөг, тоног төхөөрөмж 427.1 сая төгрөг нийт 1,701.32 сая төгрөг зарцуулж, үүнээс 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 846.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнан 855.1 сая төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй байна.
- Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Малчин түмний буян хоршоо, Чулуут сумын Нуурын овоо хоршоо, Хангай сумын Баян уулын Баян уулын хишиг хоршоод хандиваар олгосон 177.5 сая төгрөгийн Сүү боловсруулах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг акт үйлдэн өрх, хоршоо тус бүрд хүлээлгэн өгсөн боловч бүртгэл тайландаа тусгаагүй;
- Мөн Архангай аймгийн Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсгийн хөрөнгөөр баригдсан инженерийн хийцтэй худаг Өлзийт, Жаргалант баригдаж дууссан байна. Тус сумдын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн боловч нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна. ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 250 дугаар тогтоолоор төслийн нэгжийн хөрөнгөнөөс шилжүүлэн аймгийн орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгосон Жаргалант сумын Зуслан багийн Таравтад шинээр барьж байгуулсан 23.6 сая төгрөгийн худгийг тус сумын ЗДТГ нь үндсэн хөрөнгөнд бүртгээгүй;
- Дорноговь аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх Иххэт, Дэлгэрэх, Сайншанд, Айраг сумдын 20 бэлчээрт 26.6 сая төгрөгөөр ус цэг тогтоон 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 6 дугаар сарын 24-ний өдрийн хооронд гүйцэтгэж өрөмдөх цэгийг тэмдэгжүүлж акт үйлдэн баримт материалыг ажлын үр дүн, тайлан, зураг, уст цэгийн акт, зураг зэрэг баримтын хамт Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүлээлгэн өгсөн байна. Гэтэл хүлээн авсан байгууллага нь бүртгэлд тусгаагүй байна. Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 3 дугаар багийн Хар уул, Буянт сумын 2 дугаар багийн Хөлцөөтэд (Хөндий сайлын ам) барьсан гэрээний үнэ нь 46.4 сая төгрөгийн худгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/1092 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээлгэн өгсөн боловч уг хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

³⁹ АИХТ Төрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1:өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих, 10.1.3:тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт хэлэлцэх, хэрэгжилттэй холбогдуулан чиглэл өгөх,ЗД өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.2.2:тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих”

⁴⁰ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

⁴¹ Сангийн яам нь Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг мэдээлэх

Зарим төслийн үр дүнг тооцоогүй ч тухайн төсөлд нэмэлт санхүүжилт авч үргэлжлүүлж байна

2.30 ХАА-н салбарт хэрэгжиж буй зээл, тусламжууд нь 2015-2027 он хүртэл үргэлжлэх бөгөөд төсөл эхэлснээс 10-12 жилийн хугацаанд үр дүн гарч, ач холбогдлыг бий болгохоор байгаа хэдий ч зарим аймаг орон нутагт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн мэдээлэл байхгүй байгаа нь нэгдсэн дүн мэдээг гаргах боломжийг бууруулж байна.

2.31 Зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн талаар нийслэл, орон нутгийн захиргааны байгууллага салбарын яамны хамтын ажиллагаа хангалтгүй, уялдаа холбоогүй, харилцан мэдээлэл солилцдоггүйгээс хөрөнгийн ашиглалт, түүнд тавих хяналт алдагдсан байна.

2.32 Энэ нь зээл, тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр шим, сум орон хөгжилд үзүүлсэн нөлөөг орон нутгийн удирдлагууд тайлагнаж хэвшээгүй төслийн дараах үр ашгийг гаргах чиглэлээр гүйцэтгэсэн ажлын баримт байдаггүй байна. Тухайлбал:

- Бүрэнтогтох, Цагаан-уул, Цэцэрлэг сумдын 24 малчны бүлэгт нийт 133.5 сая төгрөгийн дундын санг 2017 онд хүлээлгэн өгсөн ч ашиглалт хангалтгүй;
- Бүрэнтогтох сумын дундын сан 47.3 сая төгрөгөөс одоогийн байдлаар 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Цагаан-уул сумын дундын сан 48.6 сая төгрөг, Цэцэрлэг сумын дундын сангийн 37.6 сая төгрөгийн талаар нотлох баримт мэдээлэлгүй;
- Зах зээл бэлчээрийн удирдлага төслөөс сумын сумдын Засаг даргатай байгуулсан гэрээ, сумдын засаг дарга малчны бүлэгтэй байгуулсан гэрээнд заасны дагуу сумын удирдлагууд малчны дундын сангийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй;
- Лидер кашемир ХХК-д ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зориулалтаар 3,500.0 сая төгрөгийг Хаан банкнаас авч, зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотод самнах, сүлжих үйлдвэрийн байрыг шинээр барьж, тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрийг ашиглалтад оруулсан тул орон нутагт ашиглалтыг хянах боломжгүй;
- Дундговь аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсэн судалгааны дүн нь холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэсэн дүнгээс нийт 22.6 сая төгрөгөөр зөрүүтэй нь судалгаанаас 15.1 сая төгрөгөөр илүү, 7.4 саяар дутуу;
- Гурвансайхан суманд оготно устгах 5.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж судалгааны дүнд ороогүй, Луус, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Адаацаг сумдад хийгдсэн худаг, бог малын угаалгын ванн 1.7-4.5 сая төгрөгийн зөрүүтэй;
- Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Өлзийт, Өндөршил сумдад АХБ-ны санхүүжилтээр хийсэн инженерийн хийцтэй худаг нийт дүнгээрээ 4.6 сая төгрөгийн зөрүүтэй, Луус суманд 2022 онд ирсэн хүлэмж, 2023 онд трактор, анжис анхан шатны баримтгүй үнэ тодорхойгүй тул орлогодож аваагүй;
- “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” нэгж 2022 онд төслийн хэрэгжилтэд ХШҮ хийсэн боловч хамрах цар хүрээ дутмаг байна. Хяналт-Шинжилгээ нь Үр дүн 1-рүү хэт төвлөрсөн байгаа нь Үр дүн 2, 3, 4-ын хэрэгжилт үр дүнд хяналт тавиагүй байна. Энэ нь зээлийг хөрөнгөөр санхүүжсэн техник туслалцаа, тоног төхөөрөмжийн үр дүнг тооцоход хүндрэлтэй;
- ШУТИС-ын Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн, үйлдвэрлэлийн технологийн сургуулийн хувцас судлалын үндэсний төв, Техник технологийн судалгааны төв нийт 1,918.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үр дүнг дутуу тооцсон;
- 6 аймагт хэрэгжсэн 416.9 сая төгрөгөөр хэрэгжсэн Сүү боловсруулах иж бүрдэлд хяналт-шинжилгээ хийгээгүй үр дүнд хяналт тавиагүй байна. Жишээ нь Авсан тоног төхөөрөмжөө зээлийн барьцаанд тавьсан байгаа нь зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй техник тусламжийн хэрэгжилт нь зорилтот эзэндээ хүрч чадаагүй байна.

2.33 Энэ нь зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжилт авсан иргэн, ААН байгууллага зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, дамжуулан арилжих, барьцаа хөрөнгөөр ашиглах зэрэг гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн байна.

2.34 Зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж байгаа төслийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ нь малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, тэдгээрийн эрхэлж буй ЖДҮ-г дэмжих, мэдээлэл, мэдлэгийг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгаа явуулах зэрэгт голчлон чиглэж, усжуулалтын систем, худаг усны асуудал

шийдвэрлэх, жижиг байгууламж барих, МАА, газар тариалангийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг арга хэмжээгээр хязгаарлагдаж байна.

2.35 Үүний зэрэгцээ зээл, тусламжаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь ажлын байр бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэх шаардлагатай байна.

2.36 Дээрх асуудлыг жишээгээр харуулахад АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн 50.0 сая ам.долларын санхүүжилтээр агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн ААН-д хөрөнгө оруулах замаар ХАА, хөдөөгийн хөгжлийг дэмжин, эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах салбарын бодлого зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Үүнд:

Дүрслэл 14. ХАА хөдөөгийн хөгжлийн төслийн хүрээнд төслийн хэрэгжүүлэх 4 багц ажлын задаргаа: Төслийн 1 болон 2 дугаар багцын хүрээнд хийсэн ажлууд:



Эх сурвалж: ХАА хөдөөгийн хөгжил төслийн мэдээлэл

2.37 Дээрх 4 багцын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээнд нийт 48.8 сая ам.доллар зарцуулсан бол үүний 92.4 хувь буюу 45.1 сая ам.долларыг нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтаар Нийслэл болон 18 аймагт зарцуулсан бол 19 аймагт мах, сүү, эрчимжсэн аж ахуй, арьс шир, ноос ноолуур, оёдол, тэжээлийн болон үр үйлдвэрлэл, жимсгэнэ, хүнсний ногоо даршлах, зөгийн аж ахуй эрхлэлтийн нийт 12 чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд, ААН-ийг дэмжихэд хөрөнгө оруулсан, 17 аймагт ААН-ийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах, Монголын брэндийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийх техник туслалцааны төсөл хэрэгжүүлэхэд 3.7 сая.ам доллар зарцуулсан байна.

2.38 Төслийн хүрээний эдгээр арга хэмжээг аймаг орон нутагт зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байсан эсэх, хэрэгжүүлснээр ХАА хөдөөгийн хөгжилд гарах ахиц дэвшлийг хэрхэн тодорхойлсон зэрэг чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын хийж гүйцэтгэсэн ажлыг дүгнэхэд учир дутагдалтай байна.

2.39 Зээл, тусламжаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь ажлын байр бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэж бодит үр дүнг бий болгож чадахгүй байна.

2.40 ХАА-н салбарын хөгжлийг дэмжих төслүүдийг тасралтгүй үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа ч үр дүнг нэгтгэн тайлагнасан тооцоо судалгаа, төслийн өмнөх болон төслийн дараах эдийн засгийн ач холбогдол үр өгөөжийг тооцох аргачлалгүйгээс үр дүнтэй хэрэгжсэн эсэхийг бодитой тооцох боломжгүй байна.

2.41 Иймд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон төслүүдийн ач холбогдлыг тодорхойлж, ил тод нээлттэй мэдээлэх, цаашид нэмэлт санхүүжилтээр үргэлжлүүлэх болон шинээр эхлүүлэх төслүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлж төлөвлөх, төслөөс хүртэх үр ашгийг бодитой бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна.

2.42 Харин төсөлд оролцогч ААН-ийн борлуулалтын орлого 2016-2020-д тогтмол өсөлттэй байна.

Дүрслэл 15. Төсөлд оролцогч ААН-ийн борлуулалт, экспортын өсөлт сая.төгрөг



2.43 Энэ нь нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын үр дүн 2016-2019 оны хооронд өсөлттэй гарсан боловч 2020 онд дээд үзүүлэлт буурсан байгаа нь Ковид-19 үед үйл ажиллагаа буурсантай холбоотой байна.

2.44 Харин төсөл хэрэгжүүлэгч нэгжээс дээрх тоног төхөөрөмжийн ашиглалтад үр өгөөжийг тооцоогүй, хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

2.45 Салбарын хэмжээнд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, дүгнэлт зөвлөмжийг хэлэлцэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч биелэлтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл удааширсан, зогссон, зориулалт өөрчлөгдсөн зэрэг нь зээлийн ашиглалтыг үр дүнгүй болгож байна.
- Хөдөө аж, ахуйн салбарт засгийн газрын шугамаар авч ашиглаж буй зээлийн санхүүжилтийн 16,3 хувийг буцалтгүй тусламж /бэлэн мөнгө, урамшуулал/-д, 18,0 хувийг зөвлөх үйлчилгээнд зарцуулснаар төслийн үндсэн зорилгын хамрах хүрээ хумигдсан байна.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаагүй, төлөвлөлтийн шалгуур хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь төслийн үр ашгийг бууруулж, төрөөс хөдөө, аж ахуйн салбарт баримтлах бодлогын зорилтыг дэмжихгүй байна.
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдэхгүй байгаа нь нэгдсэн шалгуур, аргачлалыг батлаагүйтэй холбоотой байна.
- Хөдөө, аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 12 төсөл, арга хэмжээг “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан” цахим системд бүртгээгүйгээс Монгол Улсын төсөв нэгдсэн байх суурь зарчимтай нийцэхгүй байна.
- Гадаадын зээл, тусламжийн зориулалт, ашиглалт, хэрэгжих хугацаа, үр дүн, холбогдох мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулаагүй нь, мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлээгүй байна.
- Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад хяналт тавьдаггүйгээс эзэнгүйдэж үрэгдэх, үнэгүйдэх эрсдэл үүсэн байна.
- Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг Монгол банкнаас баталсан банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур хангаагүй арилжааны банканд төвлөрүүлсэн нь зээлийг эргэн төлөх эх үүсвэр бүрдэхгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

Зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Сангийн сайдад

- Хөдөө, аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төслүүдийн дүн мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн санд бүрэн оруулах;
- Засгийн газрын шугамаар авсан зээл, тусламжийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг тооцох аргачлалыг баталж, мөрдүүлэх;
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үнэлэх журмыг шинэчлэх;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад

- Хөдөө, аж ахуйн салбарт зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг бүрдүүлж, зээл, тусламж хариуцсан нэгжийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй гадаад зээлийн ашиглалтыг сайжруулж, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, үр дүнг тооцох;
- Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг хүлээлцэх, данс бүртгэлд тусгаж, эзэмшигч өмчлөгч, ашиглагчийг тогтоож хариуцуулах;
- Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх;
- Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлэх заавар, арга зүйд өөрчлөлт оруулж, сонгон шалгаруулалтад оролцох жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх;

Төслийн нэгжид

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан, зөвлөх, шинжээчийг хөлсөөр ажиллуулахдаа хууль, тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулан ажиллуулж бүх татвар, шимтгэл, хураамжийг төлүүлэх;
- Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хэрэгжиж дууссаны дараа эцсийн үнэлгээг хийж харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах;
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний зориулалт, ашиглалт, хэрэгжих хугацаа, үр дүн, холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн байршуулах;
- Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгийг Монгол Улсын эрх бүхий байгууллагатай хамтран баталгаажуулах, зураг төсөлд магадлал хийлгэх, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.

Хавсралт 1.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, нэмэлт санхүүжилтийн мэдээлэл

№	Зээлдэгч нэр	Салбар	Аймаг г/хэрэгжсэн аймаг	ТУХ-оор баталсан сан огноо	Нийт санхүү жилт	Гэрээний дагуу төлөх		2023.05.29-ний өдрөөр төлсөн			Үлдэгдэл		
						Хүү	Нийт	Үндсэн төлбөр	Хүү	Нийт	Үндсэн төлбөр	Хүү	Нийт
Нэг. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл 2016-2021													
1	Монголиан Каттл ХХК	Эрчимжсэн АА	Ховд	2016.12.12	375.0	68.5	443.5	328.1	67.4	395.6	46.9	1.0	47.9
2	Ноос Ирээдүй ХХК	Ноос, ноолуур	Өвөрхангай	2016.12.12	3,000.0	606.4	3,606.4	3,000.0	606.4	3,606.4	-	-	-
3	Хан Брэнд ХХК	Сүү	УБ	2016.12.12	800.0	140.7	940.7	800.0	140.7	940.7	-	-	-
4	Монмийт Трейд ХХК	Мах, махан бүт-н	УБ, Хэнтий	2016.12.26	1,020.0	230.2	1,250.2	828.8	226.6	1,055.4	191.3	3.6	194.8
5	Русские Колбасы ХХК	Мах, махан бүт-н	УБ	2016.12.26	450.0	82.1	532.1	393.8	81.0	474.8	56.3	1.1	57.3
6	Сор Кашемир ХХК	Ноос, ноолуур	УБ	2016.12.26	5,457.3	1,023.1	6,480.4	5,457.3	1,023.1	6,480.4	-	-	-
7	Денимон ХХК	Оёдол	УБ	2016.12.12	500.0	126.2	626.2	343.7	120.9	464.7	156.3	5.3	161.6
8	Давшилт Трейд ХХК	Мах, махан бүт-н	УБ	2016.12.26	500.0	96.8	596.8	500.0	96.8	596.8	-	-	-
9	Говь ХК	Ноос, ноолуур	УБ	2016.12.12	6,000.0	1,176.5	7,176.5	6,000.0	1,176.5	7,176.5	-	-	-
10	Могол Ноос ХХК	Ноос, ноолуур	Төв	2017.03.30	2,500.0	597.3	3,097.3	1,680.0	578.2	2,258.2	820.0	19.1	839.1
11	Ханбогд Кашмир ХХК	Ноолуур	УБ	2017.03.30	5,400.0	1,221.9	6,621.9	3,643.9	1,167.3	4,811.2	1,756.1	54.7	1,810.7
12	Зургаан Хошуу ХХК	Эрчимжсэн АА	Төв	2017.03.30	1,800.0	326.0	2,126.0	1,800.0	326.0	2,126.0	-	-	-
13	Баялаг Өлзий ХХК	Ноос, ноолуур	УБ	2017.05.18	1,300.0	295.5	1,595.5	920.9	286.1	1,207.0	379.1	9.4	388.6
14	Дархан Нэхий ХК	Арьс шир	Дархан	2017.07.21	4,100.0	908.9	5,008.9	2,589.5	847.2	3,436.7	1,510.5	61.7	1,572.2
15	Түмэн Шувуут ХХК	Өндөг	УБ	2017.07.21	3,000.0	601.5	3,601.5	2,250.0	579.0	2,829.0	750.0	22.6	772.6
16	Янмал ХХК	Ноос, ноолуур	УБ	2017.12.26	3,500.0	663.0	4,163.0	2,439.4	621.1	3,060.5	1,060.6	41.9	1,102.5
17	Их Улам Ундрах	Арьс шир	УБ	2017.07.21	375.0	84.7	459.7	257.8	81.1	338.9	117.2	3.5	120.7
18	Чойрхайрхан	Ноос, ноолуур	Говьсүмбэр	2018.02.14	1,500.0	203.1	1,703.1	1,500.0	203.1	1,703.1	-	-	-
19	ГБТ Трейдиг	Даршилсан ногоо	УБ	2018.05.14	4,600.0	941.4	5,541.4	2,683.3	847.8	3,531.1	1,916.7	93.6	2,010.3
20	Хурх Гол	Үрийн үйлдвэрлэл	Хэнтий	2018.05.14	2,000.0	364.3	2,364.3	1,305.6	330.4	1,635.9	694.4	33.9	728.3
21	Жинст мөрөн	Ноос, ноолуур	Хөвсгөл	2018.05.14	390.0	53.5	443.5	381.9	53.5	435.3	8.1	-	8.1
22	Их Аураг Орд	Зөгий	Төв	2018.05.14	380.0	28.5	408.5	380.0	28.5	408.5	-	-	-
23	Нүүдэл тэжээл	Тэжээлийн АА	УБ	2018.05.14	1,315.0	298.7	1,613.7	630.1	265.2	895.3	684.9	33.5	718.4
24	Ажигана	Тахианы ферм	УБ	2018.08.29	6,000.0	1,438.5	7,438.5	2,100.0	1,145.4	3,245.4	3,900.0	293.1	4,193.1
25	Михачи	Зөгий	Сэлэнгэ	2018.10.02	600.0	108.8	708.8	397.5	97.4	494.9	202.5	11.4	213.9
26	Монгол Текстайл ХХК	Ноос, ноолуур	УБ	2018.10.02	2,000.0	357.1	2,357.1	1,194.4	311.7	1,506.1	805.6	45.4	850.9
27	Өгөөж мандал уул	Үрийн үйлдвэрлэл	Сэлэнгэ	2018.10.02	1,400.0	175.4	1,575.4	1,400.0	175.4	1,575.4	-	-	-
28	Бест шүэс	Гутлын үйлдвэр	УБ	2018.12.17	1,480.0	281.0	1,761.0	689.4	230.5	919.9	790.6	50.5	841.2
29	Мөнхбу мууд ХХК	Ноос, ноолуур	УБ	2018.12.17	958.0	111.1	1,069.1	958.0	111.1	1,069.1	-	-	-
30	Завхан баялаг	Жимс	Завхан	2018.12.17	1,088.0	210.8	1,298.8	527.5	173.9	701.5	560.5	36.9	597.4

“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”

31	Эрдмийт ХХК	Маж, махан бүт-н	Орхон	2019.05.03	2,200.0	424.3	2,624.3	928.0	335.1	1,263.1	1,272.0	89.2	1,361.2
32	Натурал Текстайл Групп	Ноос, ноолуур	Орхон	2019.05.03	7,200.0	1,461.1	8,661.1	2,760.0	1,144.2	3,904.2	4,440.0	316.9	4,756.9
33	Живэртийн Оргил	Чацаргана	УБ	2019.05.03	3,400.0	690.8	4,090.8	1,303.4	541.1	1,844.5	2,096.6	149.7	2,246.3
34	Эфэс хүнс	Маж, махан бүт-н	УБ	2019.06.24	1,500.0	117.6	1,617.6	1,500.0	117.6	1,617.6	-	-	-
35	Батсэжү	Ноос, ноолуур	УБ	2020.05.22	1,228.5	278.3	1,506.8	-	137.3	137.3	1,228.5	141.0	1,369.5
36	Жинст мөрөн	Ноос, ноолуур	Хөвсгөл	2020.12.28	500.0	100.7	600.7	33.3	48.6	81.9	466.7	52.1	518.8
37	Жүр Үр	Сүү	Орхон	2019.09.04	1,600.0	358.8	1,958.8	266.7	250.6	517.3	1,333.3	108.2	1,441.6
38	Жигд Хүч	Сүү	Төв	2019.09.04	650.0	359.3	1,009.3	279.9	87.5	367.4	370.1	271.8	641.9
39	Траст трейд	Маж, махан бүт-н	УБ	2019.09.04	6,550.0	1,437.3	7,987.3	1,091.6	1,016.8	2,108.4	5,458.4	420.5	5,878.9
40	Лидер Кашемир	Ноос, ноолуур	Хөвсгөл	2020.02.12	3,500.0	812.7	4,312.7	-	452.2	452.2	3,500.0	360.4	3,860.4
41	Үлэмж Кашемир	Ноос, ноолуур	УБ	2020.04.10	3,500.0	154.9	3,654.9	3,500.0	154.9	3,654.9	-	-	-
42	Глобал Номадик Продактс	Сүү	Архангай	2020.02.12	2,000.0	457.5	2,457.5	-	258.4	258.4	2,000.0	199.1	2,199.1
43	Эрдэнэт Мах Маркет	Маж, махан бүт-н	Орхон	2020.02.12	5,390.3	1,087.5	6,477.8	898.4	657.2	1,555.6	4,491.9	430.3	4,922.2
44	Дөрвөн Өлзий	Даршилсан ногоо	УБ	2020.02.12	3,050.0	541.4	3,591.4	699.0	373.6	1,072.5	2,351.0	167.9	2,518.9
45	Дархан цасхан сүү	Сүү	Дархан-Уул	2020.05.22	700.0	142.5	842.5	116.7	86.6	203.3	583.3	55.9	639.2
	ДҮН				106,757.1	21,246.0	128,003.1	60,757.8	17,660.8	78,418.6	45,999.3	3,585.2	49,584.5
Хоёр. Эргэн төлөлтөөс санхүүжсэн													
46	Түмэн Шулуут ХХК	Өндөг	УБ	2021.02.26	6,000.0	1,224.1	7,224.1	-	401.7	401.7	6,000.0	822.5	6,822.5
47	Жигд Хүч ХХК	Сүү	Төв	2022.10.28	2,000.0	360.6	2,360.6	-	42.4	42.4	2,000.0	318.2	2,318.2
48	Хаан хүнс ХХК	Маж, махан бүт-н	Өмнөговь	2021.11.24	3,038.2	683.5	3,721.7	-	187.3	187.3	3,038.2	496.3	3,534.5
49	Витафит милк ХХК	Сүү	УБ	2022.10.26	7,681.0	1,471.5	9,152.5	-	162.9	162.9	7,681.0	1,308.6	8,989.6
50	Солид партнерс ХХК	Сүү	Өмнөговь	2022.12.14	3,300.0	741.3	4,041.3	-	53.7	53.7	3,300.0	687.6	3,987.6
	ДҮН				22,019.2	4,481.1	26,500.3	-	848.0	848.0	22,019.2	3,633.1	25,652.3
Нийт дүн					128,776.3	25,727.1	154,503.4	60,757.8	18,508.8	79,266.6	68,018.5	7,218.4	75,236.9

Хавсралт 2. Трактор, техник, тоног төхөөрөмжийн үнэ, болон борлуулалтын мэдээ

№	Төрөл	Бараа материалын жагсаалт	Нэгжийн үнэ /евро/	Тоо	Тоо, хэмжээ /ш/				Үлдэгдэл
					Гэрээ байгуулсан он				
					2021	2022	2023	Нийт	
1	Зүтгэх хүч	Беларусь 320.4	12,100.0	21	9	9	1	19	2
		Беларусь-82.1	16,570.0	101	97	3	1	101	0
		Беларусь 952.2	19,900.0	1	1	0	0	1	0
		Беларусь-1221.2	35,500.0	10	9	1	0	10	0
		Беларусь-1523.2	47,150.0	5	3	2	0	5	0
		Анжис "ПНП-3-35" 3 корпустай	2,428.0	35	25	4	0	29	6
		Төмс ухагч КТН-2В	3,900.0	35	32	2	0	34	1

2	Төмс, хүнсний ногоо	Сийрүүлэгч манагч КОН-2,8А-35	5,335.0	35	29	6	0	35	0
		Сийрүүлэгч манагч КОН-2,8А-1	5,580.0	1	1	0	0	1	0
		Сийрүүлэгч манагч КОН-1.4А	4,235.0	20	9	9	1	19	1
		Төмс үрлэгч Л-201	2,700.0	35	23	0	1	24	11
3	Хадлан, тэжээл	Рулон хаман боогч ПР-Ф-145	7,250.0	18	3	4	0	7	11
		Хадуур КДН-210	3,100.0	62	53	3	0	56	6
		Тармуур ГВР-630	4,450.0	60	54	3	0	57	3
		Дөрвөлжин хаман боогч ППТ 160	9,800.0	60	56	4	0	60	0
4	Бусад ТТ	УХБодис цацагч ЗУБР - НШ-600	1,600.0	20	10	10	0	20	0
		Бууц цацагч ПРТ-7А	12,200.0	15	0	2	0	2	13
ДҮН				534	414	62	4	480	54

Хавсралт 3. Түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан ХАА ААН жагсаалт /2020-2023 он/ сая.төгрөг

№	ААН нэрс	Гэрээний үнийн дүн	Авсан санхүүгийн дэмжлэг	Үлдэгдэл гэрээний төлбөр
1	АЕИА ХХК	153.4	-	153.4
2	Анна энд Үлэмж Кашимер ХХК	180.5	34.9	145.6
3	Арилдий ХХК	149.3	-	149.3
4	Баяндэлгэр хүнс ХХК	131.0	125.5	5.5
5	Болор хээ ХХК	150.0	-	150.0
6	Булигаар ХХК	300.0	-	300.0
7	Бүүвэй Кашемир ХХК, Санширо ХХК	170.3	-	170.3
8	Говь ХК	150.0	146.8	3.2
9	Говь-Эрдэнэ Кашмер ХХК	92.8	46.9	45.9
10	Гоёл кашмер ХХК	49.2	33.9	15.4
11	Гоёл Кашмер ХХК	264.0	84.0	180.0
12	Грандмийт ХХК	85.5	-	85.5
13	Завхан хүнс ХХК	229.0	-	229.0
14	И Зет Лейдэр Крафт ХХК	178.8	26.9	151.8
15	Илэнхэн ХХК	58.5	43.0	15.5
16	Их халбагант	10.0	10.0	-
17	Капрадора ниттинг ХХК	220.2	220.2	-
18	Капрадородо спининг ХХК	23.8	-	23.8
19	Кашмир консепт ХХК	7.5	7.5	0.0
20	М-Агро ХХК	300.0	-	300.0
21	Мах Маркет, Ренова Говь ХХК	500.0	-	500.0
22	Мон-Ирээдүй ХХК	270.0	-	270.0
23	Монос Косметик ХХК	83.3	10.9	72.4
24	Монплеттес ХХК	209.0	60.0	149.0
25	МЧГА ХХК	17.6	10.3	7.4
26	Нанскашмер ХХК	60.0	10.0	50.0
27	Натурал Грасс Ланд ХХК	48.1	13.1	35.0
28	Натурал Текстайл Групп ХХК	142.4	-	142.4

29	Нэгүн Кашмер ХХК	58.7	27.1	31.6
30	Нэйшнлкашмер Силк ХХК	21.4	-	21.4
31	Очир Дагинас ХХК	300.0	300.0	-
32	Өгөөж шим ХХК	300.0	-	300.0
33	Прайм грийн кашимер ХХК	155.2	102.9	52.3
34	Сити Алианс ХХК	121.1	121.1	-
35	Сор Кашемир ХХК	286.9	99.5	187.4
36	ТГ ТГ ХХК	27.5	23.5	4.1
37	Траст трейд ХХК	139.6	94.5	45.1
38	Түмэншир ХХК	299.4	-	299.4
39	Тэнгэр Ертөнц ХХК	17.5	17.0	0.4
40	Фүүд интернэшнл ХХК	47.2	47.2	-
41	Ханбогд кашимер ХХК	128.2	35.4	92.8
42	Хөх Үүр Тур ХХК	11.0	10.0	1.0
43	Хүнскомплекс ХХК	58.5	-	58.5
44	Цалуут импекс ХХК	214.0	-	214.0
45	Эрдэнэ мах маркет ХХК	85.3	-	85.3
Нийт		6,505.6	1,762.0	4,743.6

Хавсралт 4. Түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан ААН экспортын мэдээ /2020-2023 сая.төг/

№	Экспортлогч	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
1	Аеиа ХХК ГХО-тай	5,553	7,981	8,013	3,823	25,370
2	Анна кашимер ХХК	20	21	38	-	79
3	Арилдий ХХК	194	2,290	2,691	965	6,139
4	Ашид гэр ххк	-	-	609	-	609
5	Ашид од ХХК	535	338	-	-	874
6	Баялаг-Өлзий ХХК	2,715	6,563	5,738	1,186	16,202
7	Бодь-Электроникс ХХК	32	28	53	157	270
8	Болорхээ ХХК	-	4	8	-	12
9	БОСА кондитер ХХК	118	-	-	118	236
10	Булигаар ХК	-	443	1,317	1,252	3,013
11	Витафит-Инвест ХХК	80	25	141	528	774
12	Гарааны Эс Ти Эс фүүдс ХХК	-	0	0	4	4
13	Глобал номадик продактс ХХК	708	663	9	557	1,937
14	Говьэрдэнэ кашмер ХХК	1,315	911	710	179	3,116
15	Гоёлкашмер ХХК	1,082	641	4,430	5,408	11,561
16	Грандмийт ХХК	-	390	724	-	1,114
17	Грэйпсити монгол ХХК	-	-	74	-	74
18	Гурвансор ХХК	615	544	401	413	1,972
19	Гэр коллекшн ХХК	14	40	36	7	97
20	ДМД МОНГОЛ ХХК	-	-	-	-	-
21	Добу технологи ХХК	-	-	-	0	0
22	Живэртийн оргил ХХК	-	-	327	325	652
23	Жонон-Од ХХК	9	95	16	-	120
24	Завханхүнс групп ХХК	-	-	213	-	213
25	И Зэт лэйдэр крафт ХХК	-	-	9	-	9
26	Интерактив ХХК	-	-	-	-	-

27	Капродоро книттинг ХХК	-	-	178	114	292
28	Кашмирконсепт ХХК	106	-	-	-	106
29	Кью Эн Эс ХХК	5	6	9	-	21
30	Летс трэвел ХХК	-	-	-	-	-
31	Лхамур ХХК	115	71	74	19	280
32	М АГРО ХХК	-	-	0	11	11
33	Марис трейд ХХК	108	95	-	48	251
34	Махмаркет ХХК	196	-	450	-	646
35	Михачи ХХК	-	-	43	-	43
36	Мон-Ирээдүй ХХК	1,812	1,183	1,745	1,085	5,825
37	Моноскосметик ХХК	-	-	1	0	1
38	Моносхүнс ХК	6	1	9	67	82
39	Монпеллетс ГХО-тай ХХК	267	325	82	-	674
40	Моншибасаки	1,567	2,161	1,302	1,150	6,180
41	Мөнхбумууд ХХК	1,701	2,738	3,407	2,773	10,619
42	МЧГА ХХК	25	-	-	-	25
43	Нанскашемир ХХК	964	1,439	1,834	1,077	5,313
44	Натурал грасс ланд ХХК	173	937	1,330	1,174	3,614
45	Натурал текстайл групп ХХК	2,515	6,008	3,037	4,026	15,586
46	Ньюжуулчин турс ХХК	-	-	-	-	-
47	Нэйшнлкашмер силк ХХК	562	482	241	383	1,669
48	Одьтан ХХК	-	0	45	6	51
49	Очирдагинас ХХК	66	73	91	67	297
50	Өгөөжшим ХХК	39	1,460	7,352	9,118	17,968
51	Прайм грийн кашемир	-	-	0	60	60
52	Реноваговь ХХК	357	-	-	-	357
53	Сан Ши Ро ХХК	273	348	260	157	1,037
54	Санкотек монголиа ХХК /ГХО/	3,565	4,612	5,562	3,573	17,312
55	Сити альянс ХХК	-	-	-	32	32
56	Содон фүүдс ХХК	-	-	-	-	-
57	Соркашемир ХХК	22,068	78,228	87,971	101,777	290,043
58	Сумака энд брадерс ХХК	0	-	-	-	0
59	Тайгын шанд ХХК	-	-	34	49	83
60	Тайгыншим ххк	-	-	-	-	-
61	Ти Эм Эл ХХК /ГХО/	85	2,098	4,967	12,516	19,666
62	Тод-Оймс ХХК	3,635	7,532	7,035	2,897	21,099
63	Трасттрейд ХХК	17,529	15,166	9,279	7,838	49,813
64	Түмэншир групп ХХК ХХК	81	133	346	723	1,283
65	Тэнгэр-Ертөнц ХХК	195	124	199	77	595
66	Увсхүнс ХК	3	0	-	-	3
67	Үлэмж кашимер ХХК	3,863	891	8,271	590	13,615
68	Фүүд интернэшнл ХХК	-	-	101	-	101
69	Ханбогдкашимер ХХК	81,834	126,772	161,588	106,513	476,707

70	Хүн-Од ХХК	174	880	-	880	1,935
71	Хүнскомплекс ХХК	0	-	-	3	3
72	Цалуут импекс ХХК	-	184	935	711	1,830
73	Чиглэл ХХК	-	-	76	8	83
74	Шар доктор ХХК	334	384	101	-	820
75	Эко-Эрдэнэ ХХК	180	98	-	-	278
76	ЭМ ЖИ КАШМИР ГРУПП ХХК	104	177	140	-	422
77	Эрдэнэтмах маркет ХХК	-	-	488	1,019	1,507
78	Янмал ХХК	836	1,343	498	573	3,249
Нийт		158,336	276,926	334,641	276,033	1,045,935



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.10.10 № 05/7417
танай 5068-09.28 ны № 01/1856 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас ирүүлсэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасныг үндэслэн "Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал авах тухай 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1856 тоот албан бичигтэй танилцаж, уг тайлангийн төсөлд өгөх санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Ж.ГАНБАТ

9765004204



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2023.10.09 № 01/3484

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай газрын АГГ-2023/25-ШТА/ГА кодтой “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал тайлбарыг хуулийн хугацаанд цахимаар хүргүүлснийг албажуулан хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт *41* хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Т.ЖАМБАЛЦЭРЭН

13301061030

“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ТАЙЛБАР

САНГИЙН ЯАМ			
	Тайлан төсөл	Ирүүлсэн тайлбар	
1	Тайлангийн төслийн 1.13 Олон улсын байгууллага, хандивлагч орны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа дараах 14 төслийн мэдээлэл <i>Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан</i> цахим систем www.odamis.mof.gov.mn /цаашид “цахим систем” гэх/- д бүртгэлгүй байна.	Уг жагсаалтад байгаа 2 зээлийн төсөл нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад хэрэгжээгүй бөгөөд цахим системд бүртгэлтэй байгаа тул жагсаалтаас хасах саналтай. Мөн бусад төслүүд нь техник тусалцааны төсөл байгаа бөгөөд уг төслүүдийн хэрэгжилт тухайн олон улсын байгууллагын журмаар зохицуулагдаж байна. Ийм төслийг цахим системд бүртгэж, холбогдох баримт бичгийг хавсаргах, цаашид Төсвийн тухай хуулийн дагуу шинээр авах гадаад тусламжийн мэдээллийг цахим системд тухай бүр бүртгэх асуудал нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хариуцах асуудал юм. Тус яамнаас уг шаардлагыг биелүүлж ажиллах тухай албан бичгийг бүх төсвийн ерөнхийлөн захирагч болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад 2022 оны 9 сарын 23-ны өдрийн 03/6542 тоотор хүргүүлж байсан.	Ирүүлсэн тайлбар саналыг судлан тайланд засвар өөрчлөлт оруулав
2	Тайлан төслийн 1.36 Үндэсний хөрөнгө оруулалтын банканд зээлийн төлөлт, хүүгийн орлого, харилцах дансны орлогоор 3,132.8 сая төгрөг, Чингис хаан банканд зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, харилцах дансны орлогоор 6,878.6 сая төгрөг нийт 10,011.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг 2016-2020 онд байршуулж мөнгөн эх үүсвэр бүрдүүлсэн байна. 1.35 Сангийн яам төслийн хүрээнд арилжааны 6 банктай Дамжуулан зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т заасныг зөрчсөн байна.	Уг аудитын илрүүлэлтэд дурдсан Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банкны асуудал шүүхийн байгууллагаар шийдэгдэж байгаа мөн төслийн хэрэгжилтийг Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжүүлсэн, төсөл 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон тул Сангийн яаманд ирүүлсэн зөрчлийн бүртгэлийг төслийн хэрэгжилтийг хариуцах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд өгөх нь зүйтэй бөгөөд тайлангийн төслөөс хасах саналтай байна.	Ирүүлсэн тайлбар ойлголтын зөрүүтэй байна гэж үзээд саналыг хүлээн аваагүй болно
ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ			
1	Тайлангийн төслийн 1.10-1.13 Олон улсын байгууллага, хандивлагч орны санхүүжилтээр хэрэгждэг 14 төсөл хөтөлбөрийн мэдээллийг Өрийн мэдээллийн нэгдсэн санд тусгаагүй тухай	Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "өр гэж өрийн хэрэгслээр дамжуулан тодорхой хугацаанд төлөх хүү, үндсэн төлбөр болон холбогдох бусад төлбөрийн үүргийг хэлнэ" гэж заасан. Олон улсын байгууллага, хандивлагч орон өөрийн санхүүжилтээр, өөрийн дэргэд хэрэгжүүлсэн техник тусалцааны төслийг Монгол Улсын засгийн газар аливаа хэлбэрээр буцаан төлөх үүрэг хүлээдэггүй болно.	Ирүүлсэн тайлбар үндэслэлгүй байх тул өөрчлөлт оруулаагүй болно.
2	Тайлангийн төслийн 1.60 Эрдэнэбүрэн, Охиндойн тал дэд төслүүд зураг төслийн алдаа, үнийн өсөлтөөс шалтгаалан зогссон	Охиндойн тал дэд төсөл нь орон нутгийн иргэдийн санал асуулгаар дэмжигдээгүй шалтгаанаар зогссон.	Ирүүлсэн тайлбар саналыг судлан тайланд засвар өөрчлөлт оруулав
3	Тайлангийн төслийн 1.62 зарим услалтын систем зогссон байхад нэмэлтээр төлөвлөсөн	Услалтын системүүд нь тус тусдаа төлөвлөгдсөн тул 1 ажил нөгөөгөөсөө хамаарахгүй болно.	Ирүүлсэн тайлбар үндэслэлгүй байх тул өөрчлөлт оруулаагүй болно.
4	Тайлангийн төслийн 1.90, 1.91 хүлэмжийн барилга барилгын тухай хуульд нийцээгүй тухай	Барилга байгууламжийн түвэгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журмын нэгдүгээр хавсралтын "Хөдөө аж	Ирүүлсэн тайлбар ойлголтын

		ахуйн зориулалттай барилга байгууламж" бүлгийн 2.18. "1 га-аас илүү талбайтай хүлэмжийн аж ахуйн байгууламж" дугаар зүйлд заасны дагуу 800м2 хэмжээтэй Дэвшилтэт технологийн өвлийн хүлэмж нь 1 га хэмжээнд хүрэхгүй тул "Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж" ангилалд багтана.	зөрүүтэй байна гэж үзээд саналыг хүлээн аваагүй болно
5	Тайлангийн төслийн 2.10 өвлийн хүлэмж 11 сараас ашиглах боломжгүй болсон	Тус хүлэмжийг ид хүйтний үед ашиглахад халаалтын зардал өндөр, эдийн засгийн хувьд үр ашиггүй тул хөрсийг амрааж, ариутган, дараа жилийн тариалалтад бэлддэг болно.	Ирүүлсэн тайлбар ойлголтын зөрүүтэй байна гэж үзээд саналыг хүлээн аваагүй болно
6	Тайлангийн төслийн 2.22 заалтын тайлбар	Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 60-р тогтоолын 27-р хавсралтаар батлагдсан Хөтөлбөр төслийн бүртгэл санхүүжилтийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд орон тооны ажилтан Э.Мөнх-Эрдэнэ томилогдон ажиллаж байна. Тушаалыг хавсаргав. АТТ-ын 2 дахь зорилтод заасны дагуу гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн судалгааг нэгтгэн үр дүнг тооцон ажиллаж байна. Төслийн судалгааг хавсаргав. Мөн Төслүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянаж үнэлгээний хороог батлуулах арга хэмжээг хариуцан ажиллаж байна. Шалгалтын хугацаанд тухайн ажилтан сургалтын чөлөөтэй байсан болно. Холбогдох тушаал, албан тушаалын тодорхойлолтыг хавсаргав.	Ирүүлсэн санал, тайлбар саналыг судлан тайланд найруулгын өөрчлөлт оруулав.
7	Тайлангийн төслийн 2.30-д заасан Дорноговь аймагт уст цэг тогтоох хайгуулын ажлыг орлогод авч, данс бүртгэлд бүртгээгүй	Уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх ажил нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын тунхаглалуудын гарын авлагын II дугаар боть Биет бус хөрөнгийн бүртгэлийн "Судалгааны үе шат"-ны 52-т заасны дагуу судалгааны зарлагыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхгүй гэж заасны дагуу бүртгэлд тусгах шаардлагагүй тул хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.	Ирүүлсэн санал, тайлбарыг судлан тайланд найруулгын өөрчлөлт оруулав.

